

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-29

*1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаарх
Засгийн газрын тайланг сонсох* 3-29

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын болон Хууль зүйн байнгын хороодын
12 дугаар сарын 12-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 34 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 55 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, С.Бямбацогт, Л.Мөнхбаатар, Ц.Туваан, Ц.Идэрбат;

Чөлөөтэй: С.Ганбаатар, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар, Ц.Сэргэлэн;

Тасалсан: Ш.Адъяаа, Г.Амартүвшин, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан.

**Нэг.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаарх
Засгийн газрын тайланг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын референт Ц.Пүрэвхүү, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр, мөн Ажлын албаны Тогтвортой хөгжлийн бодлогын хэлтсийн дарга С.Батцэцэг, ахлах мэргэжилтэн О.Буянаа, Д.Энхжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Баярбат, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Энх-Амгалан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дэд захирал Б.Нямдаваг, Батлан хамгаалах яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Батбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Саран, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Дамбий, Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлыг бууруулах асуудал хариуцсан орлогч О.Номинчимэг, Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэг, Жендэрийн асуудлаарх эрдэмтэн, судлаачдын бүлгийн ахлагч С.Түмэндэлгэр, Жендэрийн үндэсний шинжээч Б.Онон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт Л.Хурцбилэг нар байлцав.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Б.Жаргалмаа, Б.Баярсайхан, Б.Бейсен, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулшхар, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Саран нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Анужин үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг сонслоо.

Уг асуудлыг 12 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 34 минут үргэлжилж, 34 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 55.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 29 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 55 минут.

НИЙГМИЙН БОДЛОГЫН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Анужин: Байнгын хорооны хамтарсан хуралдааны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 52,9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя. Нийгмийн бодлогын байнгын хороо Баярсайхан гишүүн ирсэн байна. Бейсен гишүүн ирсэн. Жаргалмаа гишүүн ирсэн. Сандаг-Очир гишүүн ирсэн. Сарангэрэл гишүүн ирсэн. Саранчимэг гишүүн ирсэн. Одонтуяа гишүүн ирсэн. Чинбүрэн гишүүн ирсэн. Чинзориг нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна. Хамтарсан хуралдаан учраас ХЗБХ-ны ирсэн гишүүдийг танилцуулъя. Цогтбаатар гишүүн, Алтанхуяг гишүүн, Бат-Амгалан гишүүн, Мөнхцэцэг гишүүн, Пүрэвдорж гишүүн, Раднаасэд гишүүн, Сандаг-Очир гишүүн, Энх-Амгалан, Энхбаяр нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэг.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг сонсох

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн ЗГ-ын тайланг сонсоно. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт асуух, саналтай гишүүд байна уу? Байхгүй бол асуудалдаа орёе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.2.9 дэх заалтад Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн ЗГ-ын тайланг 2 жил тутам Нийгмийн бодлогын байнгын хороо болон ХЗБХ-гоор сонсохоор тусгагдсан байдаг. Ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийг орж ирэхийг урьж байна. Ажлын хэсэг өргөн бүрэлдэхүүнтэй хүрэлцэн ирсэн байгаа. Шаравын Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Төмөр-Өлзийн Энхбаяр Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, Хүрэлбаатарын Мөнхзул ХЭҮК-ын гишүүн, Самданы Цэдэндамба Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Сархадын Зулхар Хөдөлмөр, нийгэм нийгмийн хамгааллын дэд сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Сүхбаатарын Цогтгэрэл Байгаль орчин байна уу? БОАЖЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Цогтын Баярбат БХБЯ-ны ТНБД, Лхагвын Цэдэвсүрэн БШУЯ-ны ТНБД, Чойдогмэдийн Энх-Амгалан Соёлын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батаагийн Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны ТНБД, Совдын Төгсдэлгэр ЭМЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэдэнхүүгийн Пүрэвхүү ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлагын зохицуулалтын ЗГ-ын референт, Дуламсүрэнгийн Сүрэнчимэг Удирдлагын академийн захирал, Баярсайханы Нямдаваа ГХЯ-ны ТЗУГ-ын дэд захирал, Хадбаатар хэн гэж байна вэ? Т.Хадбаатар Хууль зүйн яамны ТЗУГ-ын

дарга, Жанцаны Хичээнгүй ЭХЯ-ны ТЗУГ-ын дарга, Чулуун Борын Гандирваа БХЯ-ны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Содномдоржийн Дамбий Хөдөлмөр, хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ганбадраагийн Батбаяр УУХЯ-ны ТЗУГ-ын дарга, Гомбожавын Саран ХХААХҮЯ-ны ТЗУГ-ын дарга, Бямбасүрэнгийн Онон Жендерийн үндэсний шинжээч шинжээч, Сүхбаатарын Батцэцэг Жендерийн үндэсний хорооны Ажлын албаны Тогтвортой хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, Очирхүүгийн Буянаа Ажлын албаны салбар дундын бодлого, зохицуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн, Доржготовын Энхжаргал Ажлын албаны орон нутгийн бодлого, зохицуулалтын зохицуулалтыг хариуцсан ахлах мэргэжилтэн, Дангаагийн Баярболд ЭМЯ-ны нийт, энэ биш байна. Хэлэлцэх 2 Байнгын хороо хамтарч хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг та бүхэндээ танилцуулаа.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн ЗГ-ын тайланг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Тулга танилцуулна. 4 номерын микрофоныг өгье.

Б.Тулга: Энд хүрэлцэн ирсэн эрхэм Их Хурлын гишүүд та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрвэ. Эрхэм байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2011 онд батлагдсан Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд Улсын Их Хурал ЗГ холбогдох үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнгийн талаарх тайланг

2 жил тутам хэлэлцэж дүгнэлт гаргахаар заасан байдаг. Иймд 2021 он, 2022 онд ЗГ-аас жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээг та бүхэнд танилцуулж байна. Тайлант хугацаанд гарсан тодорхой ахиц дэвшил дэвшилүүдийг тоймлон хүргэвэл 1. Дэлхийн банкнаас жил бүр гаргадаг эмэгтэйчүүд, бизнес ба хууль, эрх зүйн орчны индексийн хувьд Монгол Улс харьцангуй ахиц дэвшилтэй байна. Монгол Улс нь ижил үнэлэмжтэй хөдөлмөрт адил хэмжээний цалин хөлс олгох аргачлалыг баталж мөрдүүлсэн, хүүхэд асарч буй эцэг эх, эцэг эхэд хүүхэд асарсны чөлөө тэтгэмжийг ижил түвшинд авч үзэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Энэ нь жендерийн гол үзүүлэлт дээр 90,6 хувьд хүрч ахиц дэвшил үзүүлсэн 20 улсын тоонд багтахад нөлөөлсөн байна. Түүнчлэн ЗГ-аас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулсан Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий, Хууль зүйн туслалцааны тухай, Шүүх шинжилгээний тухай, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулиудад болон хэлэлцүүлгийн шатад байгаа Хүүхэд хамгааллын тухай хуульд жендерийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусгаж, салбарын хуулиудад томоохон ахиц дэвшил гаргаад байна.

2. Дэлхийн эдийн засгийн форумын жендерийн ялгаатай байдлын индексээр 2022 онд Монгол Улс 145 улсаас 70 дугаарт эрэмбэлэгдсэн нь эмэгтэйчүүдийн парламент дахь оролцоо, хөдөлмөрийн оролцооны түвшин нөлөөлсөн байдаг. Энэ онд батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь эмэгтэйчүүдийн парламент дахь оролцооны түвшинд бодит ахиц дэвшил авчрахаар байгаа.

3. ЗГ-аас 2023 онд НҮБ-д танилцуулсан Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний сайн дурын илтгэлийн

зөвлөмж гарсан. Энэхүү зөвлөмжийн дагуу 2 үндэсний хөтөлбөр, 1 стратеги төлөвлөгөө мөн жендерийн тусгайлсан хөтөлбөрийн 15 салбар, нийслэл, 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжүүлж байна. Батлагдсан хууль, бодлого, хөтөлбөрийг жендерийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх, үр нөлөөг нь жендерийн тэгш байдлын үзэл баримтлалын хувьд үнэлэх практик туршилагыг бэхжүүлэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагаа чухал байна. Иймд Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүдэд Жендерийн үндэсний хорооноос жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө 2022-оос 2031-ийг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4. Монгол Улсын жендерийн нөхцөл байдлын 2019 оны дүн шинжилгээ, үнэлгээгээр салбар хүрээ бүрийн жендерийн зөрөөтэй байдал сүүлийн 2 жилд хэвээр байна. Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, жендерийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендерийн бодлого, төлөвлөлтийн гүйцэтгэл, тайлагналт, хяналт шинжилгээ, үнэлгээ, жендер судлалыг хөгжүүлэх зэрэг ажлууд хэрэгжилтийн шатад байна. Харин жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт, санхүүгийн удирдлагын ажлын явц, үр дүнгийн хэрэгжилт хангалтгүй байна. Түүнчлэн тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэл, эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, арга хэмжээний төлөвлөгөө, эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрөөг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг салбарын болон салбар дундын шинжтэй бодлогуудын цар тахлын нөхцөл байдал хэрэгжүүлсэн нь 70-аас 90 орчим хувьтай тодорхой үр дүнд хүрчээ.

Иймд цаашид ЗГ-аас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. 1 дүгээрт жендер судлалын хүрээнд хүйсээр ангилсан мэдээлэл статистикийн

хэрэглээг нэмэгдүүлж боловсронгуй болгоно. 2 дугаарт хөгжлийн бодлого төлөвлөх, хөрөнгө нөөцийг хуваарилахтай холбоотой хууль тогтоомжийг жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилгод илүү нийцтэй болгох чиглэлээр холбогдох зохицуулалтыг хийн ажиллах болно. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

П.Анужин: Танилцуулга хийсэн Тулга сайдад баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Асуулт, үг хамт явна. Цэндийн Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Өнөөдөр Хуулийн байнгын хороо, Нийгмийн байнгын хороо хамтраад бас энэ жендерийн тэгш байдлын нөхцөл байдал Монголд ер нь ямар байдалтай байгаа юм бэ гэдэг талаар ЗГ-ын мэдээллийг сонсож байгаа нь сайшаалтай байна. Ер нь ЗГ жендерийн тэгш байдлыг хангахтай холбоотой хууль эрх зүйн орчин ямар байгаа юм, хуулийн хэрэгжилт ямар байгаа юм бэ гэдэг дээр бол хяналт тавьж тайлангаа тавих учиртай. Өнгөрсөн одоо өнгөрч байгаа энэ 4 жилийн хугацаанд Улсын Их Хурал дахь 13 эмэгтэй гишүүн бол ер нь энэ жендерийн тэгш байдлын бүх салбарт харьцангуй тэгш байлгах тал дээр бол нэлээн санаачилгатай ажилласан. 3 том зорилт тавиад зорилтдоо нэлээн хүрээд явж байгаа. Нэг нь бол эмэгтэйчүүдийн нас баралтын 2 дахь шалтгаан болж байгаа умайн хүзүүний хорт хавдрын эсрэг вакциныг бол товлалт вакцин болгох тал дээр ЭМЯ-тайгаа ажиллаад энэ асуудлаа ингээд хууль, эрх зүйн орчинд нь шийдээд явсан байгаа.

2 дугаарт бол улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд бид бас санаачилгатай ажилласан. Тухайлбал 2024 оны Улсын

Их Хурлын сонгуульд анх удаа квот дээр 30 хувь гэдэг тоо орж ирж, амьдралд хэрэгжих гэж байна, хэрэгжих гэж байна. Түүгээр ч зогсохгүй 2028 онд нийт нэр дэвшигчдийн 40 хувийг эмэгтэйчүүд эзлэх ийм боломжийг бид бүрдүүлж чадсан. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг 2030 онд НҮБ дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө Монгол Улс тавина. Энэ дээр бол улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог бол бид 50, 50 болгосон байх учиртай. Тэгэхдээ бид нар 28 онд 40 хувь руу хүрнэ гэдэг бол ямар ч байсан нүүр улайхгүй ийм боломжид хүрсэн байгаа.

3 дугаар асуудал бол эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцооны асуудал байна. Өнөөдөр бол ганцхан эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн тухай асуудал биш ерөөсөө дэлхийн эдийн засаг төдийлөн сайн өсөхгүй байгаа шалтгаан нь энэ дэлхийн хүн амын тухайн улс орны тухайлбал Монгол Улсын 51,3 хувийг эзэлж байгаа эмэгтэйчүүдийнхээ хөдөлмөр эрхлэлтийн оролцоо дээр төр засаг хангалтгүй анхаарал хандуулж байгаа, тэр бэлэн байгаа нөөцийг ашиглаж чадахгүй байгаа нь өөрөө эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж байгаа гэдгийг Дэлхийн банк болон Дэлхийн эдийн засгийн форум тодорхойлчихсон байна. Одоо бид энэ тайландаа, энэ үйл ажиллагаандаа эмэгтэйчүүдийнхээ энэ хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг илүүтэй сайн яримаар байна. Тухайлбал бид нар эмэгтэйчүүд, Эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх хуулийн төслийг санаачилсан. Зарим нэг эрчүүдийн зүгээс эмэгтэйчүүд рүү чиглэсэн ийм тусгай хөдөлмөр эрхлэлтийн хууль байх нь зүйтэй юү гэдэг хүртэл асуудлыг ярьж байгаа юм. Тэгш байдлыг арилгах тухай асуудал нь өөрөө аль нэг үйлсэд давуу тал олгож байгаа асуудал ерөөсөө биш. Энэ дээр ЗГ, Жендерийн үндэсний хороо анхаарах шаардлагатай гэж ингэж бодож байна.

Та бүхний энэ чиглэлээр хийх гэж байгаа ажлын талаар мэдээлэл авмаар байна.

Бас нэг хэрэгжихгүй байгаа зүйл гэвэл улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо. Тухайлбал бид нар парламентын түвшинд бол ер нь дэлхийн түвшин рүү нэлээн ойртох ийм бололцоо бүрдэж байна. Бусад түвшинд жендерийн тэгш байдлыг хангах тухай эмэгтэйчүүдийн албан тушаалд томилох тухай асуудал хуулийн хэрэгжилт огт хангалтгүй байгаа. Энийг яах юм бэ? Энэ 2 асуултад хариулт аваад, тодруулна. Баярлалаа.

П.Анужин: Сарангэрэл гишүүн асуулт асуулаа. 7 номерын микрофонд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дэд сайд Зулхар сайд хариулъя. 7 номерын микрофоныг нээж өгье.

С.Зулхар: Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэлийн асуултад хариулт хэлье. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин бол эрэгтэйчүүдтэй харьцуулах юм бол бага байгаа гэдэг нь болбол статистикаар их тодорхой байгаа. 2023, 2022 оны хувьд болбол ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдээс 14,9 хувиар бол ялгаатай байгаа юм. Тэгээд гол шалтгаан нь бол ажиллах хүчнээс гадуурх хүн амд болбол хүүхэд харж байгаа эмэгтэйчүүд 120-оос 125 мянга байдаг, гол нөлөөлөл энд байдаг. Тэрнээс гадна сурч байгаа, суралцаж байгаа иргэдийн дунд бол бас эмэгтэйчүүдийн юу өндөр байдагтай холбоотойгоор бид энэ ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой арга хэмжээ авах ёстой гэдэг ийм чиглэлтэй байгаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр болбол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ийм жишээ нь хөтөлбөр хэрэгждэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар. Энэ сангийн төсөвлөлттэй холбоотойгоор 21, 22 онд жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт хийсэн. Энэ жендерийн мэдрэмжтэй

төсөвлөлт хийсэнтэй холбоотойгоор тодорхой үр дүн гарсан эхнээсээ. Өөрөөр хэлбэл энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хувьд болбол 2021 онд болбол 39 мянга байсан, 2022 онд болбол 80 мянга болж нэмэгдсэн нийтдээ. Үүний болбол эмэгтэйчүүд бол 2021 онд 55 хувь байсан болбол 2022 онд бол 59,4 хувь болж нэмэгдсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ жендерийн мэдрэмжтэй хэрвээ бид нар төсөвлөлт хийж чадах юм болбол аль ч салбарт болбол зохих түвшний бол бас үр дүн гардаг юм байна гэсэн ийм тооцоолол гарч байна гэж байгаа юм.

Тэрнээс гадна болбол хөдөлмөр эрхлэлтийн асуудал дээр бол гол зүйл болбол хөдөлмөрийн харилцаатай уялдсан бид Хөдөлмөрийн тухай хуулийг бол шинэчилсэн. Энэ шинэчилсэнтэй холбоотойгоор энэ хууль 2022 оноос хэрэгжиж эхэлсэн. Үүнтэй уялдаад бас ажил олгогч нар ажилтныхаа ажил амьдралын жишээ нь тэнцвэртэй нөхцөлийг хангах чиглэлээр болбол үүрэг хүлээсэн. Энэтэй уялдсан зарим үр дүнгүүд гарч байгаа гэдгийг хэлье. ААН байгууллагууд тодорхой, төрийн байгууллагууд ч гэсэн дэргэдээ хүүхэд харах өрөөнүүдтэй болсон. Зарим нь цэцэрлэгтэй болсон. Энд их тодорхой тоо байна. Хүүхэд харах өрөөтэй болбол болсон байгууллагууд бол 2022 онд бол 522 байсан болбол 2023 онд 629 болж нэмэгдсэн бол, цэцэрлэг бол 68 байсан бол 75 болж нэмэгдсэн байгаа юм. Үндсэндээ өөрөөр хэлбэл эрчүүдийг, ээж нарыг, эмэгтэйчүүдийг ажил хөдөлмөрөө хийхэд нь чиглэсэн ийм нөхцөлүүдийг бол аж ахуй нэгж байгууллагууд, ажил олгогч нар бодож байвал бас тодорхой үр дүн гарах ёстой гэж үзэж байгаа юм.

Тэрнээс гадна хамгийн гол зүйл бол хөтөлбөрүүдийг цааш нь өргөжүүлэх ёстой. 2022 оноос болбол эхэлж та бүхэн мэдэж байгаа байх. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ийм хөтөлбөр бол шинээр жишээ нь батлагдаж, хэрэгжиж эхэлсэн. Энэний

үр дүн бол зохих түвшинд гарч байна. Цаашидаа энэ хөтөлбөрийг болбол үргэлжлүүлэх нь зүйтэй гэсэн ийм чиглэлтэй байгаад би хэлье. Ирэх жилээс эхлээд зэрэг саяын Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор шинэ арга хэмжээг бол бид нар авч эхэлж байна. Өөрөөр хэлбэл Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хөтөлбөрийн хүрээнд энэ Хөдөлмөрийн тухай хуулийг ажил олгогч нар болон ажилтнуудад ойлгуулах, таниулах, сурталчлах энэ ажлыг хийх юм байна гэдэг ойлголтод хүрсэн. Өөрөөр хэлбэл энэ чиглэлээрх ойлголт бол бүрэн биш байгаа юм. Бүрэн биш байгаа учраас саяын бидний өөрөөр хэлбэл ажилтны ажил амьдралын таатай нөхцөлийг, тэнцвэртэй нөхцөлийг хангах чиглэлээрх үүрэг хүлээж байгаа бол энэ рүү чиглэсэн арга хэмжээнүүдийг авах чиглэлээр энэ хуулийг сурталчилна гэж байгаа юм.

Дараагийн зүйл байгаа юм. Одоо бидэнд байгаа нэг статистик байна. Энэ хөдөлмөрийн харилцаатай холбоотой цалин хөлсний бодлого. Цалин хөлсний бодлого дээр бол яах вэ ҮСХ-ны мэдээллийг аваад үзэх юм болбол эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын цалин болбол зөрөөтэй байгаа юм. Энэ зөрөө болбол ер нь харьцангуй нөгөө дундаж цалин нэмэгдэхийн хэрээр болбол энэ нэмэгдэх ийм хандлагатай бол байгаа. Энэ цалингийн зөрөөг бол ирэх жилээс нарийвчлан судлах шаардлагатай байгаа юм. Салбар салбараар яг ижил ажил дээр үнэхээрийн ийм ялгаа байна уу гэдэг талаас нь. Яагаад гэхээр зэрэг бидний нэгдэж орсон Конвенц болон Хөдөлмөрийн тухай хуулийн өөрийнх нь үндсэн зарчим дээр болбол ижил ажилд бол ижил цалин байна гэсэн ийм жишээ нь тухайлсан зарчим байгаа. Тэгэхээр энэ зарчим болбол аль ч салбарт болбол ижил үйлчлэх.../минут дуусав/

П.Анужин: Даваажанцангийн Сарангэрэл гишүүн тодруулж асууя.

Д.Сарангэрэл: Энэ нэг жендерийн тэгш байдлын асуудал, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн тухай ярихаар зэрэг л хариулдаг нөгөө жижүүрийн тайлбараа л тавьж байна л даа. Өнөөдөр нийтдээ 44600 эмэгтэй ажил хөдөлмөр эрхлээгүй. Энэ статистик тоо ерөөсөө хөдлөхгүй их удаж байгаа юм. Өнөөдрийн байдлаар хөдөлгөж чадсан уу, хэчнээн эмэгтэйг ажлын байртай болгочхов? Нөгөө Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр байгаад байгаа зээлийн асуудлыг та хариуцдаг шүү дээ тийм ээ. Тэгээд тэр 20 тэрбумын зээл өгсөн байх учиртай. Тэр зээлийн асуудал хаана явна, хэчнээн хүнд зээл өгөв? Түүнээс эмэгтэйчүүдийн эзэлж байгаа хувь хэмжээ ямар байгаа вэ тэрийг нэг хэлье.

П.Анужин: 7 номерын микрофонд яг асуултад тодорхой хариулахыг хүсье.

С.Зулпхар: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ тухайлсан хөтөлбөрт бол 3482 хүн хамрагдсан, яг тухайлсан байдлаар эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөр шүү дээ. Эндээс болбол 556 ажлын байр бий болсон байна гэсэн бидэнд бол тоо байгаа юм. Нийт хөтөлбөрүүдээр нь аваад үзэх юм болбол энэ дээр хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 16 мянган хүн хамрагдсан, үүний 10 мянга нь эмэгтэйчүүд. Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр энэ бол бас санхүүгийн дэмжлэг олгодог хөтөлбөр юм байгаа юм. Үүнд 11869 хүн хамрагдсан байгаа юм. Үүний 6577 нь мөн жишээ нь эмэгтэйчүүд. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр байгаа. Энд болбол 24 мянган хүн хамрагдсан, 13 мянга нь болбол эмэгтэйчүүд. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээр бол 4427 хүн энэ хөтөлбөрт хамрагдсан, 2532 нь бол эмэгтэйчүүд. Ингээд нийт дүнгээрээ болбол энэ 50, энэ хөтөлбөрүүдэд болбол 59,4 хувь нь бол.../минут дуусав/

П.Анужин: Баярлалаа. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг хамт явж байгаа.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын нэг том асуудал болж байгаа жендерийн тэгш байдлыг хангах асуудал бол яах аргагүй Улсын Их Хурал, ЗГ-ын нэг гол зорилт байгаа. Тэгээд энэ хүрээнд бас бид нарын урьд өмнө бас төдийлөн хэлэлцэж байгаагүй шинэ юунууд орж ирсэн байна. Тухайлбал ЗГ-аас энэ жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг туршихаар 2 яамдыг сонгон аваад ажилласан байна. БШУЯ, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам. Тийм учраас энэ 2 яамны холбогдох асуултууд байна. Ер нь бол Монгол Улсад жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдгийг болбол төдийлөн хийж ирээгүй. Бид нарын өмнөх жилүүдийн 2011 онд Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль батлагдаад, 12 жил өнгөрч байгаа ч гэсэн нэлээд олон зорилтдоо бид нар хүрч чадаагүй. Түүний нэг нь энэ жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт байгаа. Тэгэхээр энэ ЗГ-ын энэ төсөвлөлтийн арга зүйгээ туршсан 2 яамны хувьд яг ямар дэвшилүүд гарсан бэ? Тухайлан яг жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдгийг манай энэ ЗГ-ын түвшинд яг юу гэж ойлгож байна вэ?

Ер нь болбол энэ жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэг болбол энэ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээнд тулгуурлан санхүүжилтийг тухайлан өөр, өөр байдлаар олох ийм бодлого байгаа. Энэ бол их чухал юм. Тухайлбал энэ дээр жишээлбэл ер нь төсвийн хөрөнгө оруулалт гэдэг юм уу, санхүүжилтээс нийгмийн бүлгүүд тухайлан эрэгтэй, эмэгтэйчүүдэд ялгаатай байдлаар хувь хүртдэг. Жишээлбэл манай жендер судлаачид, докторуудын судалгаанаас ингээд харахаар ер нь эмэгтэйчүүдийн олонх нь хөдөлмөрийн үнэлэмж багатай, цалин хөлс багатай ийм нийгмийн салбаруудад

илүү ажиллаж байна. Төрийн үйлчилгээний салбарууд. Тийм учраас хэрэвзээ бид нар жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт хийх гэж байгаа болбол энэ төрийн үйлчилгээний салбар дахь хөрөнгө оруулалт, цалинг нэмсэн нь тухайн салбар дахь жинхэнэ жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн нэг тод жишээ болно. Энийг манай энэ яамдууд маань хэр анхаарч явж байна вэ?

2 дугаарт нь манай Боловсролын яам болон ер нь бусад яамдад ч гэсэн анхаарах нэг асуудал байгаа юм. Жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт гэдгийг бол бид нар нэлээд тодорхой кэйсүүд дээр, тодорхой хөрөнгө оруулалтаар ярих шаардлагатай. Тухайлбал манай Монгол Улсын нийтийн үйлчилгээний газрууд, сургуулийн хүртээмж дотор ариун цэврийн хэрэгслийн хүртээмж тааруу байдаг. Английн хүүхдийн ивээх сан болон Хүүхдийн эрхийн газруудын судалгаанаас үзэхэд дунд сургуулийн ариун цэврийн хэрэгслийн хүртээмж, ариун цэврийн жорлонгийн хүртээмж тааруу, үйлчлэгч нар болон сургуулийн удирдлагууд тухайн завсарлагааны цөөхөн минутад хүүхдүүдийг үйлчлэхэд хязгаарлал тавьдаг. Тийм учраас охидууд бол энэ сургуулийнхаа жорлонгоор үйлчлүүлэх бүрэн боломж байдаггүй юм. Энэ болбол юуг харуулж байна гэхээрээ ер нь эмэгтэйчүүдэд чиглэсэн гэдэг юм уу эсвэл охидуудад чиглэсэн жендерийн төсөвлөлтийн нэг онцлог шинжийн илрэл бол энэ ариун цэврийн газрын хүртээмж гэх мэтээр их олон кэйсийг ярьж болно. Тэгэхээр энэ асуудлыг ингээд Улсын Их Хурлын түвшиндээ, ЗГ-ын түвшиндээ одоогоос ярьж байгаа маань бас тодорхой дэвшилттэй. Тэгэхдээ бид нар бол олон улсын түвшинээс их хоцор явж байна. Тэгэхээр манай энэ 2 яамны хувьд яг жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хийгээд туршсан тохиолдолд яг тодорхой ямар ажлуудыг хийсэн бэ?

Жишээлбэл Боловсролын яамны хувьд эмэгтэй багш нар, эмэгтэй сурагчдын хувьд гэдэг юм уу эсвэл тухайн жендерийн төсөвлөлт маань нийгмийн энэ бүлэгт маань хэр дэвшил авчрахаар байна гэдэг, ямар үр дүнтэй туршсан. Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яаман дээр мөн адилхан жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйгээ туршаад яг ямар тодорхой хөрөнгө оруулалтыг гэдэг юм уу, ямар тодорхой зүйлийг энэ жендерийн ялгаатай байдалд тулгуурлан бүтээчхэв? Энийг асуумаар байна. Нийт ерөнхий болбол бид нар энэ Алсын хараа бодлогодоо жендерийн асуудлыг маш бүдэг тусгаж ирсэн улс гэдгийг саяхан олон улсын парламентын үнэлгээ дээр бид нар бол хэлэлцэж ярьсан байгаа. Ер нь Монгол Улсын урт хугацаа.../минут дуусав/

П.Анужин: Мөнхцэцэг гишүүн асуултаа гүйцээж асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр ЗГ-ын болон урт хугацааны бодлогуудад жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудал маань маш бүдэг тусгаж ирсэн гэдэг маш олон судлаачид, үндэсний зөвлөхүүд бол хэлж байгаа. Тэгэхээр цаашидаа ЗГ-ын бодлогод маань жендерийн тэгш байдлыг хангах маань илүү тод тусгаж явах ёстой гэдгийг бол бас хэлмээр байна.

П.Анужин: Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн талаар тодорхой асуулт асуулаа. 2 номерын микрофонд Боловсролын яам ТНБД Цэдэвсүрэн хариулт өгье. Дараа нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бэлдэж байгаарай.

Л.Цэдэвсүрэн: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья. Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал боловсруулах энэ төсөл дээр манай яам нэг ёсондоо загвар яам болж ажиллаж байгаа. Бид нар мэдээж энэ ажлыг хийхдээ өмнө нь салбарынхаа хэмжээнд

хэрэгжүүлж байсан жендертэй холбоотой үйл ажиллагааг үргэлжлүүлэхээсээ илүүтэй энэ салбарын үйл ажиллагаа төсөвлөлтөд энэ жендерийн мэдрэмжийг хэрхэн яаж тусгах вэ гэдгийг Сангийн яам болон олон улсын зөвлөхүүдтэй хамтарч ажилласан. Нийт төлөвлөсөн арга хэмжээнүүдийн голыг танд танилцуулъя. Ер нь бол энэ жендерийн үр дүнг сайжруулах арга хэмжээний хүрээнд бид нар энэ нийслэлийн хэмжээнд цэцэрлэгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд, СӨБ-ын байгууллагын үйл ажиллагааг хэрхэн яаж мэдрэмжтэй болгох вэ, ерөнхий боловсролын салбарын дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах, ялангуяа орон нутаг дахь хүүхдүүдийн дотуур байрны орчныг сайжруулах асуудал дээр хэрхэн яаж анхаарах вэ, шинжлэх ухааны салбарын шийдвэр гаргах түвшиний эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх асуудал, бүх шатын боловсролын стандарт сургалтын хөтөлбөрт жендер болон гэр бүлийн боловсролын агуулгыг хэрхэн яаж хүүхдүүдийн нас, онцлог, сэтгэхүйд тохируулж тусгах вэ, нэг мэргэжил давамгайлсан мэргэжлийн сонголтод хүйсийн тэгш байдлыг хангах нөлөөллийн арга хэмжээг яаж зохион байгуулах вэ? Сургууль, цэцэрлэгийн багш мэргэжлээр элсэгч эрэгтэйчүүд, технологийн чиглэлээр суралцах эмэгтэй элсэгчдэд энэ төлөвлөлтийг хэрхэн яаж хийх вэ гэдэг асуудлууд дээр нэлээн голлож анхаарч, төсвийн төлөвлөлтүүдийг бол хийж байгаа.

Энийг хийхийн тулд мэдээж салбарын хэмжээний хандлага, Монгол Улсын бас иргэд болон ер нь бол нийгмийн энэ нэг эрэгтэйчүүдийн боловсролын хандлагыг өөрчлөх нь бид нарын хувьд маш чухал асуудал байсан. Энэний хүрээнд жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт болон төсөвлөлтийг хэрэгжүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх арга

хэмжээний болон эцэг эх, багш ажилтнуудын дунд нөлөөллийн арга хэмжээнүүдийг бол зохион байгуулж явуулсан. 2023 оноос эхлээд салбарын төсөв дотроо жендерийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг бол тухайлан тусгаад бид нар 24 оны төсвийн төсөвтөө бол 250 тэрбум төгрөгийг ерөнхийдөө жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдгээр нь бол тавьсан. Гэхдээ яг сайдын багцад жендерийн гэдэг үг үсэг ороогүй ч гэсэн саяын хэлсэн гол төлөвлөсөн арга хэмжээнүүддээ бол энэ мөнгийг зарцуулахаар тусгасан байгаа.

Ариун цэврийн байгууламжийн хувьд Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийнхээ дэмжлэгээр бид нар сүүлийн 2 жил аймаг, нийслэл Улаанбаатар хотын 853 цэцэрлэг, ЕБС болон дотуур байрнуудын ариун цэврийн байгууламжийг шинэчлэх ажлыг зохион байгуулаад өнөөдрийн байдлаар 250 ариун цэврийн байгууламжийг бол шинэчлээд, хүлээгээд авчихсан. Одоо 18 дээр нь комисс ажиллаад ингээд явж байна. Бид нарын төлөвлөлтөөр бол 2024 оны 4 сар гэхэд бид нар бол нийт ариун цэврийн байгууламжаа эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийнхээ нөхцөл бололцоонд хангасан байдлаар ингээд сайжруулаад орчин үеийн гэж нэрлэж байгаа энэ ариун цэврийн байгууламжийг бол хэрэгжүүлээд дуусна. Мэдээж салбарын нийт ажилтан, албан хаагчдын маань хэдэн хувь нь эрэгтэй, эмэгтэй вэ гэдгээсээ илүүтэй энэ салбарт гол нь тэгш хүртээмжтэй байдлыг бий болгох, ялгаварлан гадуурхалтыг байхгүй болгох, ялангуяа энэ хүүхдүүдийн суралцах орчин нөхцөлийг ижил тэнцүү байлгах дээр манай салбарын бодлого бол төлөвлөгдөөд ингээд явж байгаа гэдгийг бас танд хэлье.

П.Анужин: 7 номерын микрофонд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дэд сайд хариулна.

С.Зулхар: Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэгийн асуултад

хариулъя. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт, төлөвлөлт бол өөрөө манай 2 яаман дээр болбол жишиг болж хийгдсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр болбол би түрүүн хэлсэнчлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төлөвлөлт дээр. Энэ дээр тухайлан хийгдсэн юм байгаа юм. Тэгээд саяын үр дүнгүүд бол гарсан. Яг тодорхой үр дүнг бол би танд бас дахиж тодруулж хэлье гэж бодож байна. Энэ төсөвлөлт хийхээс өмнө болбол энэ сангаар дамжуулж, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хүмүүсийн 58 хувь нь болбол эрэгтэйчүүд, 42 хувь нь бол эмэгтэйчүүд байсан ийм үр дүн байсан. Тэгээд эндээс бидэнд яасан гэхээр зэрэг 1 дүгээрт энийг та хэд жендерийн жишээ нь мэдрэмжтэй төсөвлөх ёстой. 2 дугаарт эмэгтэйчүүдэд чиглэсэн тухайлсан хөтөлбөртэй болох ёстой юм байна, арга хэмжээтэй болох ёстой юм байна гэсэн ийм зөвлөмж өгсөн. Энэний дагуу тухайлсан 7 хөтөлбөр байдгаас 6 хөтөлбөр дээр нь болбол саяын жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт хийсэн. Дээр нь нэмээд болбол саяын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухайлсан хөтөлбөр жишээ нь шинээр хийсэн юм байгаа юм. Тэгээд энэний үр дүнд яг 2022 оны статистик байна. 2022 онд болбол нийтдээ болбол бид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ сангаар дамжуулж 46,7 тэрбум төгрөгийн ийм хөтөлбөр хэрэгжүүлсэн. Энд болбол 59 хувь нь бол эмэгтэйчүүд болсон гэдэг ийм нааштай эерэг үр дүн гарсан байгаа юм.

Тэгэхээр энэ бол төсөвлөлт бол хэрвээ зохистой байх юм болбол бас үр дүн гарч болдог байх нь гэсэн ийм тооцоолол. Энэ жилийн тухайд 2023 оны тухайд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулж 90,6 тэрбум төгрөгийн бид хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Энэний үр дүн бол тун удахгүй бол гарна гэсэн төсөвлөлтэй байна. Энэ жилийнхийг мөн адил 2023 оныхыг саяын жишээ нь арга зүйгээр бас хийсэн учраас

тодорхой нааштай үр дүн гарна гэсэн ийм хүлээлт байна.

П.Анужин: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

Ц.Мөнхцэцэг: Цэдэвсүрэн даргаас нэг тодруулга байгаа юм. Түрүүн нөгөө ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн мэдрэмжтэй, жендерийн мэдрэмжтэй асуудлыг тусгах тухайд илүү анхаарна гэж байгаа. Саяхан энэ Бүх нийт боловсролын төлөө үндэсний эвсэл бол бүх сурах бичиг дэх хүний эрхийн агуулгад анализ хийгээд, тэрийгээ ХЭҮК-т танилцуулсан байгаа. Тэгэхээр ер нь бол манай сурах бичгүүдийн агуулга дахь хүний эрхийн мэдрэмж, тэр дотроо жендерийн мэдрэмжтэй байдал үнэхээр хоцрогдсон байгаа. Мааш олон кэйсээр энэ бол илэрсэн байдаг. Тэгэхээр ер нь сурах бичгийн агуулгадаа хэзээ энэ шинэчлэлийг хийж амжих вэ?

П.Анужин: 2 номерын микрофонд хариулт өгье.

Л.Цэдэвсүрэн: БШУЯ-наас 2022 онд ЕБС-ийн 1-ээс 12 дугаар ангийн бүх сурах бичигт хөндлөнгийн шинжээчдийн баг ажиллуулж, үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээгээ тэгэхдээ ганцхан жендер болон хүний эрх гэдгээсээ илүүтэй ер нь сурах бичгийн агуулга яг сургалтын хөтөлбөртэйгөө нийцэж байна уу, түүнд орсон агуулгууд нь тухайн насны хүүхдийн онцлогт тохирсон бүх зүйлүүдээ илэрхийлж чадаж байна уу үгүй юү, жендер болон хүний эрхийн боловсролтой холбоотой асуудлууд хэрхэн яаж тусгасан бэ гээд. Тэгээд энэ маань бол 22 онд хийгдээд, манай Боловсролын үндэсний судалгааны хүрээлэнгийн веб сайт дээр бүх дүнгүүд нь тавигдаад, эхнээсээ энэ оны хичээлийн жилээс бид нар засвар хийгдээд, тэр үнэлгээний дүнгийн дагуу засвар нь хийгдээд, сурах бичгүүд 23-аас 24 оны хичээлийн жилд сурагчдад бол түгээгдээд эхэлчихсэн байгаа. Энэ дээр

бас нэг хүлээгдэж байгаа асуудал нь юу вэ гэхээр сая энэ онд батлагдсан Боловсролын ерөнхий хууль болон дагалдах 4 хуулийн хүрээнд энэ цэцэрлэг, ерөнхий боловсролын.../минут дуусав/

П.Анужин: 2 номерын микрофонд асуултад гүйцээгээд хариулья 1 минутад.

Л.Цэдэвсүрэн: Цэцэрлэг, ЕБС-ийн сургалтын агуулга хөтөлбөрийн үзэл баримтлал бүхэлдээ шинэчлэгдэх ийм хуультай. Хуулийг хэрэгжүүлэх үүднээс Боловсролын хүрээлэн энийгээ хийж дуусаад, улсын хэмжээний олон удаагийн хэлэлцүүлгүүд зохион байгуулаад, энэ сарын 25-нд бид нар энийг Боловсролын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх гэж байна. Энэ зөвлөл энэ хэлэлцүүлгийн дараа энийг ЗГ батлах ёстой хуулиараа. ЗГ батлагдсаны дараа хөтөлбөрүүд шинэчлэгдэж түүний дагуу сурах бичгүүдийн шинэчлэл үргэлжлээд 24 оноос хийгдэж эхэлнэ.

П.Анужин: Салдангийн Одонтуяа дарга асуулт асууж, үг хэлье.

С.Одонтуяа: Тэгэхээр бид нар энэ Сонгуулийн хууль, Улс төрийн намын хуульдаа бас нэлээд сайн амжилт гаргачихлаа гээд баярлаад байтал жендерийнхээ энэ олон улсад байгаа индексээр нэлээд ухарчихсан байгаа юм л даа. Тэгэхээр би энэ ухарч байгаа асуудлыг бол энэ хөдөлмөр эрхлэлттэй холбоотой юм уу гэж харсан. Тэгэхээр 2000 онд жишээлэхэд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт 60,9 байсан бол одоо 49 хувь гэхээр чинь энэ чинь их буугаад байгаа юм. Тэгэхээр яг эмэгтэйчүүдийг л энэ хөдөлмөр эрхлэлтийнх нь асуудлыг их дэмжмээр байгаа юм л даа. Ялангуяа Хөдөө аж ахуйн яам дээр бичил, жижиг бизнес эрхлэх тэр зээлийг нь түлхүү өгөх гээд энэ дээр их сайн ажиллах хэрэгтэй. Тэгэхээр надад энэ талаар мэдээлэл тусад нь ирүүлж өгөөч. Одоо яг эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар өнгөрсөн 3 жилд яг юу

хийсэн юм бэ гэдгийг тусад нь надаа ирүүлчхээрэй.

Би энэ хэн Тулга сайд гараад явчихлаа. Энхбаяр даргаас асуухаас. Энэ жендерийн тайланг харахаар яг аль салбар хамгийн муу энэ үүргээ биелүүлсэн байна вэ? Ерөөсөө энэ Жендерийн тэгш байдлын хуулиа хангахгүй, хэрэгжилтээ хангахгүй энэ яг аль салбар байна? Тэгвэл бид нар энэ салбартаа бас түлхүү ажиллаж болно. Тэгээд энэ дээр ингээд муу ажиллалаа гээд хариуцлага тооцсон зүйл байдаг юм уу? Энэ ямар нэг та нар ЗГ-ынхаа хэмжээнд энэ, энэ үүргийг биелүүлээгүй учраас энэ дээр ийм, ийм арга хэмжээ авлаа гэсэн тийм хариуцлага тооцсон зүйл байна уу гэдгийг асууя.

3 дахь нь энэ жендерийн зохистой харьцаа манайд их олон салбарт алдагдаж байгаагаас асуудлууд үүсээд байгаа юм. Жишээлэхэд би боловсролын салбараас асуух гээд байна л даа. Голцуу эрэгтэй багш нар их байдаг учраас энэ дээр асуудлууд хүмүүжлийн гэдэг ч юм уу асуудлууд гардаг гээд. Тэгэхээр энэ чиглэлээр яг хийсэн зүйл байна уу? Зохистой харьцааг хадгалах, аль болохоор бас эрэгтэй багш нарыг түлхүү ажиллуулах ч гэдэг юм уу. Эрүүл мэндийн салбарт бас яг энийг асуух гээд байна л даа. Яагаад гэхээр надад эрүүл мэндийн салбар дээр очихоор аягүй их гомдол ирдэг юм. Юу вэ гэхээр маш хүнд, хүнд өвчтөнүүдийг ингээд өргөж барих, хагалгаанд аваачихад дандаа хөөрхий нэг хэдэн асрагч, сувилагч нэг туяхан хүмүүс хийдэг. Гэтэл бусад оронд чинь болбол бүүр яг тэр ажлыг хариуцсан дандаа эрэгтэй ажилтнууд байж байгаа юм. Тэгэхээр манайх энэ чиглэлээр ер нь яг юу хийсэн юм бол? Ийм 4 асуулт.

П.Анужин: 5 номерын микрофонд Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга Энхбаяр эхлээд хариулт өгье.

Т.Энхбаяр: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн энэ 2 жил тутам Улсын Их Хуралд танилцуулдаг тайланг 21, 22 оны мэдээг бол хамарч байгаа, тайлант хугацааг хамарч байгаа. Тэгэхээр 21, 22 оны тайланг бид нар нийт салбарын яамнууд болбол 21 аймаг, нийслэл, 9 дүүргээс болбол хуулийн хэрэгжилтийг бол татаж энэ тайланг бол боловсруулсан байгаа. Таны асуултын хүрээнд болбол төрийн захиргааны төв байгууллага буюу салбарын 16 яам, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар тодорхой чиг үүрэг хүлээдэг. Энэ чиг үүргийн хүрээнд бид нар 41 шалгуур үзүүлэлтийг олон улсын бөгөөд дотоодын шинжээчдийн бүлэгтэй ингэж хамтарч эрдэмтэн судлаач, багш нартай боловсруулж, бид нар 41 шалгуур үзүүлэлтийг гаргаж гаргасан.

Энэ 41 шалгуур үзүүлэлтийг 16 яамаар бид нар ингэж үнэлэхэд 50-аас дээш хэрэгжилттэй болбол 4 яам байгаа ХЗДХЯ, БХБЯ, ХНХЯ, ГХЯ. 50-аас доошоо буюу өөрөөр хэлбэл энэ нөгөө хэрэгжих шатдаа байж байгаа яамнууд бол ингээд Сангийн яам, Боловсролын яам гээд, ингээд яамнууд бол ингээд ар араасаа бас ингээд тайланд жагсаж байгаа юм. Хэрэгжилт хангалтгүй байгаа яамнууд гэдэг дээр болбол дандаа ерөнхийдөө нөгөө шинээр байгуулагдсан 2 яам бол орж ирж байгаа юм. Нөгөө хуулийн шалгуур үзүүлэлтээр сүүлийн 2 жил дөнгөж байгуулагдсан яамнууд учраас Цахим хөгжил, харилцаа яам, Эдийн засгийн хөгжлийн яамнууд болбол шинэ байгуулагдсан яам учраас зарим нөгөө шалгуур үзүүлэлт бол хангагдахгүй байгаа. Яг одоо тогтмол үйл ажиллагаа явуулж байсан гэдэг дээр ЭХЯ, ЭМЯ гэсэн яамнууд бол 35-аас 38 хувийн Жендерийн хуулийн хэрэгжилтийн 41 шалгуур үзүүлэлтийн хүрээнд болбол үнэлэгдсэн. Энэ асуудлыг болбол бас ингээд тайланд бид нар дурдсан байгаа.

Мөн бас таны асуудлаар бид нар бас 21 аймаг, нийслэл, 9 дүүргээ 31 шалгуур үзүүлэлтээр бас үнэлж, энэ тайлан дээр бас ингээд аймгуудыг нийт авсан оноогоороо бас ингэж жагсааж оруулсан байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

П.Анужин: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Одонтуяа даргад түрүүн тэр хүссэн мэдээллийг тийм ээ, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн статистикийг маш тодорхой өгөөрэй гэдэг хүсэлт тавьсан. Үүнийг бол ойрын хугацаанд хариуцлагатайгаар өгөхийг хүсье. 7 номерын микрофонд ЭМЯ ТНБД-ын албан үүргийг орлон гүйцэтгэгч Төгсдэлгэр дарга хариулт өгье. ЭМЯ, дараа нь Боловсролын яам бэлдэж байгаарай.

С.Төгсдэлгэр: Манай салбарын хувьд бол нийт ажилчдын 82 хувь нь эмэгтэйчүүд байгаа. Үүн дотроо сувилагч, эх баригч нарын тухайд болбол энэ хувь нь бүүр их 90 гаруй хувь нь эмэгтэйчүүд байгаа. Тэгээд энэ манай салбарын хүний нөөцтэй холбоотой энэ асуудлыг шийдвэрлэхийн төлөөнөөс АШУИС-д элсэгчдийн анагаахын сургуулиудад элсэгчдийн хувьд квот тогтоох, эрэгтэй элсэгчдийн хувьд босго оноог бууруулах зэрэг асуудлуудыг бид нар БШУЯ-тай бас санал солилцож үзсэн. Энэ болбол хуулийнхаа зохицуулалтаар боломжгүй юм байна лээ. Тэгээд бас хүний эрхийн асуудлууд нэлээн яригддаг, ХЭҮК-оос бид нарт бас яг ийм хариултыг ирүүлж байсан учраас бид нар бол аль болохоор эрэгтэй хүүхдүүдийг элсэлтэд хамруулахыг зорьж байгаа боловч одоогийн байдлаар болбол ямар нэгэн онцгойлсон хөшүүрэг бол бид нарт эрх зүйн хувьд боломжгүй байгаад байна.

Тэгээд энэ эмэгтэйчүүд давамгайлсан хүний нөөцийн хувьд эмэгтэйчүүд давамгайлсан байгаа асуудал нь өөрөө манай салбарын хувьд жендерийн тэгш байдлыг хангах 3

чиглэлийн хүндрэлтэй асуудлуудын нэг нь яах аргагүй мөн. Бид нарын хувьд болбол бас БХЯ-тай хэдэн жилийн өмнө тэр нөгөө цэргийн дүйцүүлэх албанд тодорхой зарим тэр дүйцүүлэх албаны хүмүүсийн нөгөө алба хаахын асуудлыг нь энэ эмнэлгүүдэд асрагчаар, сувилагчаар ажиллуулах ийм байдлаар дүйцүүлж болох уу гэдэг асуудлуудыг бас хэлэлцэж үзэж байсан. Энэ дээр бас тодорхой ахиц дэвшил гараагүй байгаа.

П.Анужин: Боловсролын яам 2 номерын микрофонд хариулья. Хариулахдаа Цэдэвсүрэн дарга та энэ сая асуултад дутуу хариулагдсан. Хуулиар зохицуулалт хийх боломжгүй гэж байна. Анагаахын салбарт тэр дундаа сувилагчдын 90 хувь нь эмэгтэйчүүд байгаад байхад бид нар хуулийн зохицуулалт хийж чадахгүй. Хуулийн зохицуулалт байхгүй хэр нь нийгэмд бүүр сөрөг үр дагавар нь гараад ирсэн. Нийгэмд заавал зайлшгүй зохицуулах шаардлагатай энэ асуудал дээр яаж Боловсролын яам энэ талаар нэг яригдаж байсан санагдах юм. Энэ дээр яг Боловсролын яам ямар бодлого баримталж байгаа вэ? Журам ийм нэмэлт зүйлүүд юу байна вэ? Энийг гүйцээгээд хариулахыг хүсье. 2 номерын микрофон Цэдэвсүрэн сайд хариулья.

Л.Цэдэвсүрэн: Одонтуяа гишүүний асуултад хариулья. Салбарын багш, ажилтны хүйсийн харьцаанаасаа өмнө ер нь Монгол Улсад цэцэрлэг, ЕБС энэ бүх шатын сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхдүүдийн маань хувь ямар байгаа гэдгийг бас гишүүддээ нэг хэлэх нь зүйтэй байх. Өнөөдөр цэцэрлэг, ЕБС мэргэжлийн сургууль, их, дээд сургуульд 1 сая 100 гаруй хүүхдүүд суралцаж байна. Боловсролын түвшин ахих тусам хүйсийн харьцаа алдагдах хандлага сүүлийн жилүүдэд явж байгаа. Явж байгаа. Одоо нийт суралцагчдын маань 49,4 хувь нь эрэгтэй хүүхдүүд. Энэ нь 590-ээд мянган суралцагч гэсэн үг. 50 гаруй хувь нь эмэгтэйчүүд 600 гаруй мянган хүүхэд гэсэн үг л дээ. Тэгээд

харьцаа хаана алдагдаад байна гэхээр ЕБС-ийн ахлах ангиас, мэргэжлийн сургалт болон их дээд сургууль руу элсэх энэ шатан дээр харьцаа алдагдаж байна. Яагаад энэ тоог хэлж байгаа юм бэ гэхээр энэ тоо ирээдүйн нөгөө хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудалтай бас уялдаад байгаа юм.

Яг боловсролын салбарын хувьд бол нийт 52 мянга гаруй ажилтан албан хаагч юу багш нар байгаагаас гишүүнээ 18,3 хувь буюу 9,7 мянга нь л эрэгтэй багш нар байна. Тэгээд энэ хүмүүс дийлэнх нь хаана багшлаад байна вэ гэхээр мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага дээр эрэгтэй багш нарын маань тоо илүү давамгай байдаг. Тэгээд сая Анужин дарга хэллээ. Бид нар энэ ялангуяа анагаахын чиглэлийн ялангуяа нөгөө нэг эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хүйсийн асуудалтай холбогдуулаад хэрвээ та бүхэн маань санаж байгаа бол бид нар 2000 оны эхээр яг энэ дээр нэг хууль, бодлого гаргаж үзсэн. ЗГ-аас тодорхой арга хэмжээ авч, яг ялангуяа яг маш хүнд хэлбэрийн мэргэжлүүд дээр эрэгтэй хүүхдүүдийг түлхүү элсүүлэх ч гэдэг юм уу, 9 дүгээр анги төгсөөд ахлах ангид ороход нь эрэгтэй хүүхдүүдийн тоог тодорхой хувиар нэмэгдүүлэх ч гэдэг юм уу. Гэвч энэ маань бол нэг жил хэрэгжээд зогссон. Яагаад гэхээр Үндсэн хууль зөрчиж байна гэдэг асуудлаар. Үндсэн хуульд хүн өөрөө мэргэжил боловсролоо сонгох эрхтэй. Тэгэхэд тухайн хүний сонголт дээр та нар ЗГ нөлөөлөл үзүүлэх боломжгүй гэдгээр ингээд зогсож байсан юм тэгээд. Энийг л сая нөгөө хуулиар энэ хүний мэргэжил эзэмшихтэй холбоотой асуудлыг зохицуулах боломжгүй юм байна гэдгийг ЭМЯ маань хэлчихлээ гэж би ойлгож байна.

Бид нар аль болохоор хүүхдүүдээ иргэдээ боловсролд тэгш хамруулж, ирээдүйн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлуудыг нь багаас нь ингээд хууль юу хөтөлбөртөө оруулаад явуулж байгаа боловч хувь хүний

сонголтод нөлөөлөх нөлөөлөл бол яг ахлах анги дээр тулгараад ирж байгаа. Энэ дээр нь ирээдүйн мэргэжил эзэмшихтэй холбоотой ажлуудыг бол сүүлийн бараг 10 гаруй жил нэлээн сайн нөлөөллийн арга хэмжээ хийж байна. Хийж байгаа боловч хүүхдүүд хэрхэн яаж мэргэжлээ сонгох вэ гэдэг нь хувь хүний сонголтын асуудал болчхож байгаа учраас жоохон асуудлууд үүсэж байгаа. Үүнийг бол яг үнэндээ бол шууд хуульчлах боломж бол байхгүй, байхгүй. Боломж ч бас нэлээн хязгаарлагдмал гэдгийг бас хэлэх гэсэн юм .

Сүүлийн жилүүд дээр бид нар энэ ЕБС-ийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнаар одоо бид нарын бэлдчихсэн байгаа хүмүүс маань дийлэнх хувь нь эмэгтэйчүүд байна. Гэтэл ямар сөрөг юм гарч байна гэхээр эрэгтэй хүүхдүүд эмэгтэй сэтгэл зүйч, эмэгтэй нийгмийн ажилтантай харьцах харьцаа нь бас арай доголдоод байна. Тэгээд энэ дээр энэ жил л манай яам бас бодлого барьж, аль болохоор эрэгтэй сэтгэл зүйч, эрэгтэй нийгмийн ажилтнуудыг бэлтгэх дээр Боловсролын их сургуулийнхаа элсэлт дээр нэлээн анхаараад, энэ дээр бас нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж байгаа.

П.Анужин: Одонтуяа дарга тодруулж асууя.

С.Одонтуяа: Энэ бусад орны жишиг ямар байдаг юм бол? Жишээлэхэд бид нар ингээд элсэлтийн шалгалт авахад л дандаа нөгөө Үндсэн хууль руу яагаад л, Үндсэн хууль зөрчинө, Үндсэн хууль зөрчинө гээд ингээд аваад байгаа шүү дээ. Тэгээд энэ чинь яг гол харьцааг алдагдуулаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь салбарын харьцаа юм чинь бусад орнууд энийг болбол зохицуулдаг зохицуулалт бол байгаа л байх. Жишээлэхэд бол уурхайн салбарт манайх тэдээс тийм бодлогоор эрэгтэй хүмүүс авна ч гэдэг юм уу, тийм салбарын бодлого нь энэ дээд сургуульд

элсэгчдэд яг бусад оронд ямар байдаг юм бол?

Би ЭМЯ-ны хувьд бол нөгөө эмч нарын хувьд бол хэлээгүй юм. Анагаахын тэр элсэлт, эмч нар биш. Нөгөө туслах ажилтнууд дээр л ямар бодлого байна гээд байгаа юм. Туслах ажилтнуудад бол мэдээж жоохон тодорхой цалин мөнгөнөөсөө л болдог байх л даа. Тэгээд энд чинь ийм яг төрийн бодлого байна уу, энийг урамшуулал юмаар зохицуулсан тийм заалтууд байдаг юм уу л гэсэн юм.

П.Анужин: Эхлээд ЭМЯ хариулъя, ТНБД Төгсдэлгэр дарга хариулъя. 7 номерын микрофоныг нээж өгье.

С.Төгсдэлгэр: Энэ дээр бол яг мэргэжил сонголт дээр хамгийн гол нөлөөлдөг хүчин зүйл нь бол цалин байдаг юм байна лээ. Бусад улс орнуудад эмч, эмнэлгийн ажилчдын цалин нэлээн өндөр учраас харьцангуй тийм нөгөө хүйсийн харьцаа дээр өндөр хөгжилтэй болон дунд орлоготой улс орнуудад бол манайх шиг ийм ноцтой асуудал бол харьцангуй гайгүй байдаг юм байна лээ. Тэгэхээр эмч, эмнэлгийн ажилчдын цалин өндөр байвал тийшээ бас нөгөө эрэгтэй хүмүүс өрх гэрээ тэжээнэ гэдэг утгаараа өндөр цалингаа хараад очих тэр хөшүүрэг нь бол болдог. Манай салбарын хувьд болбол сувилагч, эрх баригч, дунд мэргэжилтнүүдийн хувьд гэхэд хөшүүрэг нь бүүр л муу, цалин нь бүүр л бага учраас эрэгтэй хүмүүс энэ салбарыг сонирхож орж ирэхгүй 1 дүгээрт. 2 дугаарт энэ бол аягүй их өргөн хүрээний нийгмийн асуудал байгаад байгаа. Одоо зөвхөн эрэгтэйчүүд гэлтгүй эмэгтэйчүүд ч гэсэн энэ мэргэжлийг сонгох хүн асар цөөрч байна. Манай салбар болбол хүний нөөцийн асар их хомсдолд орох бодит эрсдэл бий болчхоод байна.

П.Анужин: Болсон уу? Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууя.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Тайланг сонсоход бас таатай сайхан мэдээллүүд дуулдаж байна. Цаашидаа ч гэсэн хийж хэрэгжүүлэх ажил дээр бас гойд анхаарах зүйлүүд бас байгаа нь харагдаж байна. Хууль, эрх зүйн хүрээнд гэдэг юм уу бас шийдвэр гаргах түвшинд улс төрийн оролцоон дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх гээд хууль, эрх зүйн хүрээнд бас тодорхой хэмжээнд үр дүн гарч, энэ нь эргээд нийгэмд бас нөлөөлж байна уу гэвэл нөлөөлж байгаа. Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль гээд. Ер нь болбол бид нар бүүр төсвөө хүртэл жендерийн мэдрэмжтэйгээр төсөвлөдөг болсон гэдэг сайн үзүүлэлтүүд байна л даа.

Бид ер нь яагаад жендерийн эрх тэгш байдлыг хангах ёстой, нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил байр суурь нь байх ёстой юм бэ гэдэг энэ мэдээллийг гэдэг юм уу, энэ судалгааг хийдэг ийм судалгааны бие даасан байгууллага манайд байдаг уу? Энэ судалгаа дээр үндэслээд ийм хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт шаардлага байна ч гэдэг юм уу. Ийм учраас гээд нийгэмд тийм ээ олон нийтэд мэдээллийг түгээдэг, олон нийтэд нөлөөлөх тэр нөлөөллийн ажлыг хийдэг, ЕБС-ийн хүүхдүүддээ тийм хүргэсэн тийм үйл ажиллагааг хийдэг ийм төв гэдэг юм уу тийм ээ, бас нэг ийм байгууллага ер нь байдаг уу манайд? Энэ талаар эхлээд нэг тодруулъя гэж бодож байна.

2 дугаарт ер нь энэ судалгаа дээр үндэслээд гэдэг юм уу, бид нар цаашдынхаа авч хийх, хэрэгжүүлэх ажил дээр олон улсын байгууллагын хийсэн дүн шинжилгээ дээр тулгуурлаад цаашдынхаа ажлыг бас төлөвлөх ёстой байдаг байх гэж би бодож байна. Тэгээд ер нь төрийн албан хаагчдыг мэргэшүүлж сургах тал дээр сургалтын агуулгад жендерийн үзэл баримтлалыг тусгаж байгаа нь амжилттай боловчиг цаашид хувийн хэвшлийнхэнтэй яг энэ

чиглэлээр ер нь хэрхэн яаж ажилладаг юм бэ? Хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын хооронд бас нэг ялгаа байдаг. Тэгэхээр энэ тал дээр ер нь хэр ажиллаж байна вэ гэдэг зүйлийг асуумаар байна. Өөрөөр хэлэх юм бол жендерийн мэдрэмжтэй ажлын байрны соёлыг бас төлөвшүүлэх нь бас нэг шаардлага байх гэж би харж байна.

2 дугаарт энэ тайланд дурдсанаар үндэс НҮБ-ын Үндэсний сайн дурын илтгэлд эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх ажлыг бас хурдасгах шаардлагатай гэсэн байна тийм ээ. Өөрөөр хэлэх юм бол шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог мөн бас нэмэгдүүлэх ёстой гэдэг ийм чиглэл өгсөн харагдаж байна л даа. Яг энэ чиглэлд бодитой бид нар юу хийж чадаж байна вэ гэдэг зүйлийг асууя.

2 дугаарт зүгээр жендер ярихаар зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал ярьдаг гэдэг шүүмжлэл бас бидэнд байдаг. Гэхдээ мэдээж шаардлагатай учраас бид ярьж байгаа. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах л талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гэж бидэнд байгаа. Ер нь эрүүл чанартай зөв насжилт, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн насжилтын байдлыг харах юм бол эрэгтэйчүүд маань арай өмнө нь явчихдаг ийм тоон үзүүлэлт маш ихээр гардаг. Тэгвэл яг энэ чиглэлд чиглэсэн ажлыг ер нь бид нар хийж чадаж байна уу үгүй юү гэдэг нэг ийм 4 асуулт байна тийм ээ. Энэ 4 асуултад хариулт аваадахъя.

П.Анужсин: 5 номерын микрофонд Жендерийн үндэсний хороо хариулт өгье. Байгууллага байдаг уу, аргачлалаа яаж хийдэг юм бэ гэдгээр тодорхой хариулт авъя.

Т.Энхбаяр: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Эхний 3 асуултад хариулъя. Судалгаа хийдэг яг дагнасан

байгууллага өнөөдөр яг төрийн өмчийн оролцоотой ийм байгууллага бол байхгүй байгаа. Жендерийн үндэсний хорооны дэргэдэх үндэсний шинжээчдийн бүлэг болоод эрдэмтэн судлаачдын бүлэг, их дээд сургуулиудыг хамаараад нэг судалгааны ажлуудыг хийдэг. Мөн манай төрийн албан хаагчдыг сургаж байгаа Удирдлагын академи дээр бас дагнасан чиглэлийн судалгаанууд бол ингэж төрөлжүүлж байгууллагууд дээр хийж байгаа. Яг жендерийн чиглэлийн үндсэн судалгааны төв бол байхгүй. Энийг Улсын Их Хурлын даргын санаачилгаар МУИС-ийг түшиглэсэн Жендер судлалын төв байгуулах эхний алхам бол хийгдчихсэн байгаа. Тэгээд энэ ажил бол 23-24 онд бол хийх ийм төлөвлөгөөтэй байгаа гэдгийг хэлье.

Асуулт 2 дээр болохоор тогтвортой, хувийн хэвилийн байгууллагуудад жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг нэвтрүүлэх чиглэлд бол 1 дүгээрт ажлын байрны жендерийн мэдрэмжтэй бодлого бол 2022 оны 12 дугаар сард Хөдөлмөр, нийгэм хамгааллын 3 талт үндэсний хороогоор бол батлагдсан. Энэ бодлогыг болбол хувийн хэвилийн байгууллагуудад түгээх 3 том байгууллага бол Жендерийн үндэсний хорооны гишүүнээр бас нэмж оруулсан нь МҮХАҮТ, Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо. Тэгэхээр эдгээр байгууллагуудын хийж байгаа бүх гишүүнчлэл, сургалтын модуль хөтөлбөрт жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг оруулах, үзэл баримтлалыг нэвтрүүлэх, тэгээд ААН байгууллагуудад хүргэх энэ ажил болбол тухайн нөгөө нэгдсэн холбоодоор нь дамжуулаад бас ингээд хийгдэх ажил энэ жилээс бол эхэлж байгаа. Нөгөө өнгөрсөн жилийн оны тайланд болбол дөнгөж бодлого нь батлагдсан учраас 2022 оны 23 оны эхний хагас жилийн байдлаар бол бид нар нийтдээ 4 аймгийн 125 ААН-д бол жендерийн Ажлын байрны жендерийн мэдрэмжтэй бодлогыг болбол зааж сургалтаар бол

хүргэсэн. Бусад ААН-д бол байгууллагынх нь гишүүнчлэлээр хүргэж байгаа гэдгийг танд хэлье.

3 дахь асуултын хүрээнд болбол тогтвортой хөгжлийн сайн дурын илтгэлийн хүрээнд болбол бид нар нийтдээ охид, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх буюу илүү л нөгөө эдийн засгийн эрх мэдэлтэй байх, энэ хурдасгах гэдэг ажил дээр болбол Улсын Их Хурал дахь Сарангэрэл нарын эмэгтэй гишүүдийн маань санаачилсан Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийг болбол энэ парламентаар бас батлуулах маш том зорилттой. Энэ дээр бас ингээд хороо болон байгууллагууд бол хамтарч ажиллаж байгаа энэ ажил. 2 дугаарт нь болбол энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр бас манай ХНХЯ, дээр нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хууль, эрх зүйн орчин бол батлагдсан. Одоо энийг 24 онд бас амжилттай хэрэгжүүлэхэд Жендерийн үндэсний хороо түүний Ажлын албаас улс төрийн намуудтай бид нар хуульд заасан чиг үүргийн хүрээнд бас хамтарч ажиллах, 24 оны эхний хагас жилийн төлөвлөгөө гаргаж ажиллаж байна.

П.Анужин: Баярлалаа. 7 номерын микрофонд Эрүүл мэндийн яам эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс бага байгаа талаар, энэ дээр яг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, бодлогын талаар асуулт асуусан. 7 номерын микрофон Төгсдэлгэр дарга хариулт өгье.

С.Төгсдэлгэр: Эрэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дундаж наслалт манай улсад эмэгтэйчүүдээс 9,6 жилээр богино байгаа. Энэ бол дэлхийд 12-т, Ази Номхон далайн бүсэд бол 2-т орохоор ийм өндөр үзүүлэлт байгаа. Энэний гол үндсэн шалтгаан нь бол архины хэрэглээ. Тэгээд хүн хоорондын хүчирхийлэл, осол гэмтэл, бас нэг томоохон нөлөөлж байгаа хүчин зүйл болбол эрүүл мэндийн

тусламж үйлчилгээнд хамрагдах зан үйл хангалтгүй байгаатай холбоотой байгаа. Тэгээд энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд яагаад эрэгтэйчүүд ингэж бага, хойрго хамрагдаж байна вэ гэдгийг бид нар салбарынхаа хэмжээнд судалж үзсэн. Нэг гарч ирж байгаа томоохон нөлөөлж байгаа хүчин зүйл нь эрэгтэйчүүд эмэгтэй эмчид бас тэр өвчин зовлонгоо ялангуяа залуу эмэгтэй эмчид эрэгтэй хүн өвчин зовлонгоо ярьж орохоос нэлээн цааргалдаг. Тэр утгаараа бас эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдах нь муу байна гэсэн ийм үзүүлэлтүүд гарсан байгаа.

Тэгээд хамгийн гол хэрэгжүүлэх энэнээс юуны дундаж наслалтын зөрөөг багасгах хамгийн гол арга хэмжээ болбол энэ архины хорт хэрэглээтэй тэмцэх явдал байгаа. Тэгээд энэ дээр болбол архины, архи худалдаалах цэгийн тоог бууруулахаас өгсүүлээд маш олон арга хэмжээнүүд авах шаардлагатай байгаа. Харамсалтай нь сүүлийн үед бол бид нар энэ архи борлуулах цэгийнхээ тоог нэмсэн ийм ухралт гарсан байгаа. Мянган хүнд 4 байсныг 6 болгосон ийм ухралт гарсан байгаа. Тэгээд энэ дээр болбол ер нь нийгмийн бүх салбарууд яг энэ чиглэлээр эрүүл мэндийн энэ бодлогыг дэмжсэн шийдвэр гаргахад анхаарах нь асар чухал байгаа гэдгийг хэлмээр байна.

П.Анужин: Жаргалмаа гишүүн тодруулъя.

Б.Жаргалмаа: Сая яагаад жендерийн эрх тэгш байдал бидэнд өнөөдөр нийгэмд хэрэгтэй вэ гэдэг маш тод жишээг Төгсдэлгэр дарга хэлчихлээ л дээ. Өөрөөр хэлэх юм бол эрчүүд маань эмэгтэй залуу эмч нарт очиж үзүүлдэггүй байгаагаас шалтгаалаад өвчлөл бас өндөр байдаг. Урьдчилан сэргийлж чаддаггүй гэж. Одоо бид нар бас Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль яг хэлэлцэгдэж байгаа энэ цаг мөчид энэ асуудал ч гэсэн бид нарын хувьд яригдаж байгаа. Тэгвэл яг энэ мэтээр нийгэмд

чинь ийм нөхцөл байдал байгаад байгаа учраас бид энэ жендерийн эрх тэгш байдлыг хангахын тулд ажиллаж байна гэдэг нийгэм рүү чиглэсэн, олон нийт рүү чиглэсэн ийм ажил хэрэгтэй санагдаад байгаа байхгүй юу. Энэ жендер гэдэг чинь бол зөвхөн эмэгтэй хүний асуудал биш, эр, эм хүйсийн тэгш байдлын асуудал гээд ингээд ярихаар, бид нар ч гэсэн Жендерийн үндэсний хороон дээр бодлогын зөвлөлд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хамтдаа байж энэ асуудлыг шийдье гэдэг ийм шийдэлд хүрээд ажиллаж байгаа. Тэгвэл яг энэ судалгаа дээр суурилсан бодлого бидэнд хэрэгтэй юм биш үү л гэж би асуугаад байгаа юм. Тэгэхээр судалгааны ажлаа идэвхжүүлэх зайлигүй шаардлага байгаа нь саяын ганц жишээ дээрээс харагдаад байгаа. Тэгэхээр энэ дээр л илүүтэй түлхүү ажиллах ёстой юу үгүй юү? Үнэхээр ЗГ-аас хийж хэрэгжүүлж байгаа ажил хууль, эрх зүйн хүрээнд 50-аас дээш үнэлгээтэй байна гэдэг олон улсын дүн гарч байгаа нь үнэхээр талархууштай боловчиг бидэнд хийх ажил маш их байна шүү гэдэг нь бас энэ саяын жишээгээр харагдаад байна гэдгийг би хэлэх гэсэн юм.

Нөгөө талаар хүүхэд, охид, эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхаас ангид байлгах энэ үүрэг амлалтаа, энэ тийм ээ үүргээ бид нар хэрхэн яаж биелүүлж байна вэ гэдэг дээр онцгой анхаарах зайлигүй шаардлага байгаа. Өнөөдөр ЕБС-ийн эрүүл мэндийн хичээл, биеийн тамирын хичээл, биологийн хичээл ямар нөхцөл байдалд ороод байгаа вэ гэдэг дээр Боловсролын яам анхаарах зайлигүй шаардлага байгаа. Эрүүл мэндийн хичээлийг энэ физикийн багш нь орчхоод, физикийн бодлогоороо эрүүл мэндийнхээ хичээлийг дүгнэнэ гээд сууж байна гэдэг бол энэ өөрөө яг энэ бодлого бидэнд алдагдаад байгаагийн бас л нэгэн жишээ. Тэгэхээр энэ бүхэн дээр бид нарын цаашидын анхаарах асуудал байгаа шүү гэдгийг бас онцгойлон хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

П.Анужин: Жаргалмаа гишүүн санал хэллээ. Балжиннямын Баярсайхан гишүүн үг хэлж, асуулт асууна.

Б.Баярсайхан: Баярлалаа. Өмнөх гишүүд асуух гэж байсан асуултуудыг бас нэлээн давхардуулж асуусан учраас би онцгойлон энэ хөдөө орон нутагт жендерийн тэгш байдал хэр хангагддаг юм бэ, хангагдаж байгаа вэ? Жендерийн тэгш байдлын талаарх ойлголтыг хөдөө орон нутагт та бүхэн маань хэр их түгээн дэлгэрүүлж байгаа вэ? Ялангуяа залуу малчдын залуу, малчдын залуу халлаа тасарч байна гэдэг ийм аюул хөдөө орон нутагт нүүрлэж байгаа. Тэгвэл өнөөдөр 21 дүгээр зууны охид, эмэгтэйчүүд өөрийнхөө төрсөн нутагтаа юм уу үлдээд, мал аж ахуйгаа эрхлээд явах боломж, тэдний эрх тэгш байдал, эрхийн асуудал, наад захын хүний эрхийн асуудал хэрхэн хангагдаж байна гэж та нар үзэж байгаа юм бэ? Өнөөдөр Монгол Улсын ЗГ-аас хөдөө, хотын сэргэлт ижил тэгш байдалд хөгжих талаар нэлээн олон арга хэмжээ авч байгаа. Тэгээд малчин эмэгтэйчүүдийн тал дээр та нар маань ямар бодлогын ажил хийж байгаа юм бэ, ямар соён гэгээрүүлэх ажил хийж байгаа юм бэ? Энэ эрх тэгш байдал хэр хангагдаж байгаа юм бэ гэдэг дээр маш тодорхой хариулт авъя. Тэгээд шаардлагатай бол тодруулж асууя. Баярлалаа.

П.Анужин: Баярсайхан гишүүн маш чухал асуулт асуулаа. Би яг асуулттай холбогдуулаад өөрөө дараа нь асуух гэж байсан юм, хамтатгаад асуучихъя. Энэ бид нар эмэгтэйчүүдийн улс төрлийн оролцоог нэмэгдүүлэх талаар Улсын Их Хурал дээр ярилцаж байхад эрчүүд маань нэг ийм хариулт хэлж байсан. Улс төрд нэр дэвшиж, улс төрд орох нь байтугай хөдөө тогоо барих эмэгтэй олохгүй байна гэдэг зүйлийг эрчүүд ярьж байсан. Тэгээд энэ Монгол гэр бүлийн ялангуяа хөдөө дэх гэр бүлийн бүтэц алдагдаж байна хөдөөд, эмэгтэйчүүд маш багасаж байна. Энэ асуудал бас хөдөөгийн асуудалтай

холбогдож яригдах ёстой. Эдгээр асуудлуудыг нэгтгээд хариулт авъя. Эхлээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулъя. Дараа нь Боловсролын яам хариулъя. Хүнс, хөдөө аж ахуйн яам ч бас нэмэлт хариулт өгөх ёстой. 7 номерын микрофонд Зулхар сайд хариулт өгье. Малчин эмэгтэйчүүдийн асуудал байна, хөдөлмөр эрхлэлтийн асуудал байна, хүн амын бодлогын асуудал байна Зулхар сайдаа. Булгантуяа сайд өөрөө ирсэн байна, дэд сайд манайтай хамаагүй асуудал гээд. Баярсайхан гишүүн тодруулаад асуултдаа тодруулж асууя.

Б.Баярсайхан: Уучлаарай. Энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам манай асуудал биш гэж байна. Энэ бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны гол асуудал. Хүн ам зүйн бодлогыг хариуцаж байгаа яамны хувьд. Бид нар малын талаар яриагүй байна. Хүнсний талаар яриагүй байна. Энэ хүнсний салбар, хөдөө аж ахуйн салбарыг авч явах хүний талаар буюу хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа жендерийн эрх тэгш байдал алдагдсан талаар мөн малчдын халаа залгамж халаа байхгүй байгаа талаар ярьж байна. Тэгэхээр энийг Хүнс, хөдөө аж ахуйн яамны асуудал гэж ингэж болохгүй. Энэ бол маш хариуцлагагүй хариулт байна шүү дэд сайдаа.

П.Анужин: 7 номерын микрофон одоо юу хариулах вэ дээ. Түүрүүн асуултаа сонсоод, манай асуудал биш гээд ярьчихсан хүн. Та нараас мал, хүнс, тэжээлийн асуудал яриадах гэж асуулт асуугаагүй шүү дээ. Тэнд байгаа гэр бүлийн бүтэц алдагдаад байна, малчин эмэгтэйчүүд малчдын удам судар тасраад байна, энэ бодлого ямар байгаа юм бэ гэж байна шүү дээ. Нийгмийн асуудал асууж байна шүү дээ. Та нар энэ саяын Баярсайхан гишүүний асуусан асуулт дээр хариултыг тодорхой өгөөрэй гэдгийг хүсье. Та нараас бол одоо хариулт авахгүй, түүрүүн та нар манай асуудал биш гэсэн учраас, маш харамсалтай байна. Жендерийн

үндэсний хороо хариулт авъя гэж байна, 5 номерын микрофон.

Т.Энхбаяр: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. 2021 онд Жендерийн үндэсний хорооны Ажлын албанаас Боловсролын яам болоод бусад салбарын яамнуудтай бид нар бас хамтраад малчин, залуу, эмэгтэй гэр бүлийн ийм үндэсний судалгааг бол бид нар хийсэн юм, 7 аймаг, 20-иод сумыг бол хамруулаад. Тэгээд энэ яг малчин нөгөө залуу гэр бүлд тохиолдоод байгаа, гэр бүл төлөвлөлтийн асуудал буюу малчдын төлөвлөлт дээр асуудал үүсээд байгаа дээр, дээр нь нөгөө бага боловсрол эзэмшүүлж байгаатай холбогдуулаад эцэг эхчүүд сумын төв дээр тусдаа амьдарч байгаа гэдэг асуудал ер нь жендерийн дүн шинжилгээгээр байнга гарч байгаа. Тэгээд энэ судалгааг 2021 онд хийхэд ер нь малчин залуу гэр бүлийн үндсэн тулгамдаж байгаа бол хэд хэдэн асуудал гарсан. Эмэгтэйчүүдийнх нь хувьд болбол өнөөдөр бид нар тэнд нөгөө мал маллах сонирхол нь бол байгаа. Гэр бүл төлөвлөөд амьдрах сонирхол нь байгаа. Гэхдээ хүүхдэд бага боловсрол олгох асуудал нь өөрөө жендерийн нөгөө ээлгүй байгаа гэдэг дээр энэ 1 дүгээр тайланд бол дурдагдсан. 2 дугаарт нь малчин эмэгтэйчүүд өөрөө орлоготой байх асуудлыг болбол энэ тайланд бас дурдсан байдаг.

Бид нар зөвхөн мал аж ахуйн бүтээгдэхүүнээс гадна яг бидний гар дээр өнөөдөр хүүхдийн мөнгөний л орлого орж байгаа гэдэг энэ асуудал. Тэгэхээр яаж бид нар бас эдийн засгийн орлоготой байх вэ гэдэг асуудал. 3 дугаарт нь малчин эмэгтэй мал аж ахуйгаа эрхлээд амьдрахад дэд бүтэц буюу өнөөдөр бид нар мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөр бид нарт ээлтэй байдлаар сургалт хүргэх асуудал, дээр нь бид нар халуун усанд орох хэрэгцээ, ном унших, хүүхдүүддээ хичээл заах энэ дэд бүтцүүд өөрөө энэ аж ахуйг эрхлэхэд бий болох нь аягүй чухал байна. Ингэж гэмээ нь гэр бүл малчин эмэгтэй

тэнд мал аж ахуйгаа эрхлээд амьдрах боломж бий. Тэгэхээр тулгамдаж байгаа асуудал нь бол ийм байна гэдэг бол үндэсний судалгаа гарсан. Энэ судалгааны тайланг бол бид нар ингээд бүх холбогдох салбарын яамнуудад бас хүргүүлж бол ажилласан байгаа.

П.Анужин: Баярсайхан гишүүний хариултад бид нар бас хариулт авна. ХХААХҮЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Саран ирсэн байгаа. 1 номерын микрофонд энэ хөдөөгийн бодлого хариулт өгье. 1 номерын микрофоныг нээж өгье.

Г.Саран: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Нийт хүн амын амын ер нь 8,9 хувь буюу 305 мянган малчин байгаа гэсэн статистик байна. Нийт ажиллах хүчний бол 24,9 хувь нь малчин, малчдын 181,8 мянган хувь нь, мянга буюу 59,6 хувь нь бол эрэгтэй байна гэсэн ийм судалгаа байгаа юм. Тэгээд 123,3 хувь нь буюу 40,4 хувь нь эмэгтэй. Тэгээд малчдын эрэгтэй малчдын тоо жилээс жилд өсөөд давамгайлсаар эрэгтэйчүүд бол давамгайлсаар байна гэсэн ийм үзүүлэлтүүд байна. Тэгээд манай яамнаас бол нэг ялангуяа энэ статистикийн статистиктай холбоотойгоор бид бас ингэж шинэчилжээ гээд арга хэмжээг зохион байгуулсан. Энэ арга хэмжээ нь ямар учиртай гэхээр нөгөө жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар хөндөгдсөн нөгөө мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын бүртгэл буюу нөгөө малчдын А данс байгаа. Өрхийн мэдээлэл зөвхөн өрхийн тэргүүлэгчийн мэдээлэл оруулдаг байсныг гэр бүлийн гишүүдийн мэдээлэл оруулдаг байхаар санал гаргаад өгсөн байгаа. Энэ яагаад ингэж өгсөн юм гэхээр хэрвээ ороод явах юм бол Үндэсний статистикийн газар бид саналаа хүргүүлчихсэн байгаа. Хэрвээ энэ асуудал шийдэгдэх юм бол 123,3 мянган эмэгтэй малчдын эрх хөндөгдөөд тус яамнаас олгож байгаа урамшууллыг өөрийнхөө дансаар авах боломжийг боломж нь бол эмэгтэйчүүдэд өөрсдөд бүрдэнэ гэдэг юм

уу энэ бас чухал асуудал байна гэж ингэж үзсэн.

Мөн бас залуу малчдын сургалтын тогтолцоог хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх төслийг бол 21 оноос хойш бол хэрэгжүүлээд явж байгаа. Төслийн хүрээнд болбол нийтдээ 4 бүсэд бол 18-аас 35 насны залуучуудыг бол хамруулсан. Тэгээд жендерийн буюу хүйсийн тэгш харьцаа тэнцүү байхаар залуу малчдыг оруулж зохион байгуулж байгаагаараа бас онцлог байгаа. Нийтдээ 28 аймаг болон нийслэлийн 509 малчин оролцоно. Энэ дээр бас эмэгтэйчүүд маань 157 эмэгтэй, 352 нь болбол эрэгтэй малчин байгаад байгаа. Мөн 9, 9 сургалтыг бол чадамжид суурилж болбол бас зохион байгуулаад ингээд явж байгаа. Ер нь яамны хувьд болбол жендерийн бодлогоо болбол гаргачихсан. 2018-аас 23 онд хэрэгжүүлэх жендерийн бодлогоо бол гаргаад ингээд явж байгаа. Баярлалаа.

П.Анужин: Баярлаад байх ч юу байх вэ. Жендерийн бодлогоо гаргасан юм бол жендерийн бодлогоо л сая танилцуулах ёстой шүү дээ та. Түүнээс биш таныг энд хүрч ирээд статистик нийт малчдын тэдэн хувь нь эмэгтэй, тэдэн хувь нь эрэгтэй гэдгийг ярь гээгүй шүү дээ. Энэ статистик чинь бидэн дээр байна, алдагдчихаад байна. Тэгээд яах вэ гээд асуугаад байхад статистикийн тоо та яриад байна. Жендерийн бодлогоо гаргасан байгууллага ингэж ярьдаггүй юм. Баярсайхан гишүүн өөрөө тодруулах уу, тодруулъя.

Б.Баярсайхан: Миний хувьд бол бараг танин мэдэхүйн шинж чанартай юм асуучихъя. Энэ малчдын асуудал, малчин хүний асуудал яг ямар яаманд харьяалагддаг юм бэ гэдгийг надад нэг тодруулаад өгөөч. Энэ жендерийн эрх тэгш байдал гэж бид нар ярьж байгаа боловч хүний эрх, хүний амьд явах эрх, хүний ая тухтай амьдрах эрх, хүний хөдөлмөрлөх эрх, хүний айдасгүй орчинд амьдрах эрх ярьж байна шүү дээ. Энэ

хот, хөдөөгийн хөгжил тэнцэл, хэнийг ч орхигдуулахгүй байх гээд л бид нарын тунхагладаг олон сайхан бодлогуудын үр нөлөө нь хөдөө яаж хэрэгжиж байгаа юм бэ? Яаж соён гэгээрүүлж байгаа юм бэ? Энэ жендерийн эрх тэгш байдлын энэ талаар ойлголт байгаа юм уу л гэж би асуусан. Энэ асуудал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүний асуудал харьяалагдахаа больчихсон юм уу тийм ээ? Энэ юуг л чиг үүргээ л надад нэг тодорхой хэлээд өгчих, яамны чиг үүргээ.

П.Анужин: Энэ бол бас асуудал мөн шүү. Бид нар малаа тоолж ирсэн. Гэтэл нөгөө талд нь бид нар энэ малыг хариулдаг малчид хэн бэ, малчдын асуудал юу вэ гэдгийг анхаарч ирээгүй. Тэр малыг малладаг гэр бүлийн бүтцийг бид нар анхаарч ирээгүй. Сүүлдээ ингээд яамд нь хоорондоо асуудлаа шидэлцээд, ингээд хариуцдаг яамгүй гэдгийг гэдэг ойлголт төрөхүйц ийм байдлаар өнөөдөр төрийн энэ өндөр албаны ажилчид хандаж байна. Энэ асуултад хариулт авъя. 1 дүгээрт нь Хүнс, хөдөө аж ахуйн яам. Та нар энэ малчдын асуудлыг ерөөсөө ярихгүйгээр шийдсэн юм уу, та нарт хамаагүй юу? Хариулт авъя. 1 номерын микрофоныг нээж өгье.

Г.Саран: Малчдын асуудал бол хамаатай, хамааралтай.

П.Анужин: Микрофондоо ойртоод хариултыг тод дуугаар тодорхой өгье, бас энэ чинь минут чинь яваад, хязгаартай хугацаа байгаад байна.

Г.Саран: Малчдын хөдөлмөр эрхлэлтийн асуудал, нийгмийн асуудал бол Хүнс, хөдөө аж ахуйн яамтай бол хамааралтай. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал, бодлого нь бүгдээрээ хамааралтай гэж үзэж байна.

П.Анужин: Гэж үзэж байна. Гэж үзэж байгаа юм байна. Танайхаас энэ манай Байнгын хороо танайхаас ер

нь юмаа мэддэг хүнээ ирүүлж болоогүй юм уу? Энэ бүх яамнуудыг оролцсон хүний эрх, жендерийн асуудал ярьж байхад сайд байхгүй юу? Энэ чинь юу болж байна вэ? 7 номерын микрофонд Зуллхар сайд бас хариултаа өгчихье.

С.Зуллхар: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Нийгмийн бүлгүүдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал гарцаа байхгүй манай яамны чиг үүрэг мөн. Саяын малчидтай холбоотойгоор малчдын нийгмийн хамгааллын чиглэлээр болбол нийгмийн даатгал, нийгмийн халамжийн бодлогын хүрээнд болбол тодорхой шийдвэрүүд гарсан. Хамгийн ойрын шийдвэр бол Нийгмийн даатгалын багц хууль батлагдахтай уялдаатайгаар малчин малчдын өөрөөр хэлбэл 290 мянган малчин байгаа. Эдгээр малчдын нийгмийн даатгалд хамрагдах болбол 5 хүртэл жилийн хугацаанд НДШ-ийг төрөөс хариуцахаар ийм шийдвэр гарсан. Энэ болбол нэг талаар бас яах вэ хөдөлмөр эрхлэлттэй, нийгмийн хамгаалалттай уялдсан бас ийм шийдвэр. Сая би таны асуултыг буруу ойлгосон байна. Та бас уучлаарай. Гарцаа байхгүй манай асуудал. Хөдөлмөр эрхлэлтийн холбоотой малчдын асуудал бол мөн адил манай асуудал мөн. Энэтэй уялдсан байдлаар малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухайлсан хөтөлбөр болбол хэрэгждэг. Тэрнээс гадна саяын бид эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гэсэн тухайлсан хөтөлбөрүүд байгаа юм. Энд бас орон нутагт болон малчид.../минут дуусав/

П.Анужин: Тийм байлгүй дээ. Зуллхар сайд бол бас хариуцлагатай бас энэ яамны асуудлаа сайн мэддэг хүн асуултыг буруу ойлгосон байна гэдгээ бол хэлж байна. 1 номерын микрофон Хүнс, хөдөө аж ахуйн яам бол арай дэндүү хариуцлагагүй байна. Танаас

эрхэлдэггүй ажлыг чинь асуугаагүй. Бүх яамнуудын ТНБД нар энэ жендерийн асуудлаа хамаарч, хариуцаж ажилладаг байгаа. Тэгэхээр таны яг хариуцаж байгаа ажлыг асууж байгаа болохоос биш энд орж ирээд Монгол Улсын хүн ам зүйн бодлогыг танаас асуугаагүй шүү. Энэ тал дээр энэ хурлыг үзэж байгаа энэ зохих яамны сайд болоод хариуцлагатай хүмүүс хариуцлагатай хандаж арга хэмжээ авахыг хүсэж байна. Хурлыг энэ чинь хурал биш инээдэм ханиадам болгож байна шүү дээ. Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Энэ тайлантай танилцлаа л даа. Жендерийн эрх тэгш байдлаа хангах талаар аймаг, нийслэл, дүүргийн жендерийн дэд хөтөлбөрийг хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна л даа. 11 аймагт л үнэлгээ хийсэн юм байна, 12 аймаг, 5 дүүрэгт нь үнэлгээ хийгээгүй байна. Ер нь энэ дэд хөтөлбөр чинь төсөвтэй хөтөлбөр юм уу, төсөвгүй хөтөлбөр юм уу? Төсөвтэй байвал хэчнээн тэрбум төгрөгийн төсөвтэй юм бэ? Төсөвгүй болчихоод энэ та нар юу үнэлгээ хийхгүй байна уу? Хэрэгжилт муу л байна л даа 1 дүгээрт. 2 дугаарт энэ хугацаа нь зарим нь дууссан байна, яах вэ зарим нь хэрэгжих шатдаа явж байгаа. Энэ талаар асууя 1 дүгээрт.

2 дугаарт энэ би эрүүл мэндийн салбарын хүн учраас эрүүл мэндийн салбарын эмэгтэйчүүдийн эрх маш ихээр зөрчигдөж байгаа. Цалин бага, боловсролын салбар мөн адилхан. Тэр цалингийн 10, 20 хувийн нэмэгдлийг үндсэн цалинд нь нэмж болдоггүй юм уу? Гадаад улс орнуудтай харьцуулахад би 3 жил ярьж байна Их Хурал ирчхээд. Үндсэн цалингийн сүлжээг 2 дахин нэмэхгүйгээр энэ цалин нэмлээ гээд яриад байх шаардлага байхгүй байна. Инфляц үнийн өргөн хэрэглээний барааны үнийн нэмэгдэл, бензин шатахууны нэмэгдэл дийлэхгүй байна шүү дээ. Ялангуяа энэ эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж байгаа улсууд 80 хувь нь

эмэгтэйчүүд байгаа, бүүр сувилахуйн салбарын 90-ээс 95 хувь нь эмэгтэйчүүд байж байгаа. Эд нарын бүүр 80-аас 90 хувь нь цалингийн зээлтэй, хүүхдээ сургаж байна. Үнэхээр энэ хүрэхгүй байна. Энийг үндсэн цалингийн сүлжээнд нэмэх боломж бий юу?

2 дугаарт энэ батлан хамгаалах, хилийн цэргийн албан хаагчид томилогдоод ажилладаг. Гэр бүл нь энэ эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөөд, энэ жил яах вэ төсөвт тусгалаа, 24 онд тусгалаа гээд тэгж байгаа. Нийгмийн даатгалын шимтгэл нь тасраад, цаашид тэтгэвэр авах эрх нь үүсэхэд нэг хүндрэлтэй байдал үүсэж байгаа. Энийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нөхөж төлөх асуудал дээр энэ чинь батлан хамгаалах салбар үндэсний аюулгүй байдал дээр ажиллаж байгаа улсууд шүү дээ. Энийг нөхөх талаар баримталж байгаа бодлого бий юу? Энэ жил төсөвт тусгагдсан байвал энэ хэрэгжих үү энийг асууя.

Мөн сая эрүүл мэндийн салбарын сувилагчдын асуудлыг ярилаа. Цалин нь үнэхээр бага байгаа. Гадаад ихээр явж байна. Гадаадад 3-аас 5 сая, 7 сая төгрөгийн цалинтай байхад манай сувилагч нар 700-аас хамгийн хүнд салбар нь сая 200 л авч байна шүү дээ. Юунд ч хүрэхгүй байна. Нөгөө талаар сувилагчийн хомсдолд орж байна. Хэчнээн сувилагч эмнэлгүүдээр юугаа гаргасан уу, сувилагчийн дутагдал хэр байна, ачаалал нь хэр байна вэ? Улиран ажиллаж байгаа улсууд, зарим нь улирч ажиллаж байна, зарим нь нөхөж гарч байна цалин авахын төлөө. Энэ ачаалалтай холбоотой энэ сувилагчдын ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах талаар энэ байгууллагууд яаж ажилласан. Сая Сувилахуйн албаны улсуудыг бас буруутгасан. Сувилагч нарыг. Тэр талын асуудлыг энэ цаг дуусаж байна. Дараа нь тодруулна бас асууна. Яг энэ 3 асуудал дээр боловсрол, хил хамгаалах байгууллага, Нийгмийн

хамгааллын яам, Эрүүл мэндийн яам 4-өөс асууя.

П.Анужин: 5 номерын микрофонд Жендерийн үндэсний хороо яагаад энэ 11 аймгийг сонгож энэ үнэлгээг хийсэн бэ, бусад нь яасан бэ? Холбогдуулаад төсвийн асуудлыг асууж байна. Тодорхой хариулт өгье. Дараагийн асуудлууд болбол яах вэ хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоогүй ч гэсэн сувилагч нарын нөгөө хүйсийн байдлаар эмэгтэйчүүд давамгайлдаг гэдэг утгаар нь холбож асууж байгаа юм болов уу гэж ойлгож энэ сувилагч нарын асуудалд хариулт авъя. Тэр батлан хамгаалахын цалин нэмэгдэх асуудлаар асуусан. Хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоогүй учраас Бейсен гишүүнд бичгээр хариулт өгөхийг хүсэж байна. Энэ 2 асуудал дээр хариулт авъя. 5 номерын микрофоныг нээж өгье.

Т.Энхбаяр: Бейсен гишүүний асуултад хариулъя. 2017 оноос хойшоо жендерийн бодлого төлөвлөлт болбол Монгол Улсын түвшинд болбол нэлээд ийм эрчтэй явж байгаа. 23 оны, 22 оны 12 сарын 31-ний байдлаар 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг жендерийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа. Хөтөлбөр болгон дээр ер нь бол 2 жил тутамд хөндлөнгийн үнэлгээг тухайн аймаг, нийслэл, дүүргийн ТББ-аар захиалан хийлгэнэ гэсэн ийм нөгөө заалттай. Тэгэхээр эдгээр үнэлгээний 50 орчим хувийг болбол орон нутгийн ЗДТГ-аас буюу өөрөөр хэлбэл санхүүжилтийг өөрсдөө санаачилж жил бүр манай хөтөлбөрийн үнэлгээ болбол хийгдэх болж байгаа юм байна гэдгийг Хорооноос болбол чиглэлүүдийг өгдөг. Нөгөө өмнөх чиглэлийнх нь зөвлөмжүүдийг, тайланг нь үнэлээд зөвлөмж өгөхдөө танайх дараа жил дэд хөтөлбөрийн үнэлгээнд үнэлгээгээ хийнэ, төсөв мөнгөө төсөвлөөрэй гэдэг чиглэлүүдийг өгдөг. Тэгэхээр энд бол нөгөө манлайлж ажиллаж байгаа тухайлбал энэ аймгууд нь болбол яг цэвэр үнэлгээгээ хийгээд ажилладаг.

Хөтөлбөрийн үнэлгээ болоогүй аймгууд нь болбол тухайн үнэлгээг болбол хугацаанд нь хийхээр бас ингээд шахдаг.

Нийтдээ бид нар энэ тайланд нийслэл, 21 аймгийг 31 шалгуур үзүүлэлтээр бол үнэлсэн. Тэгэхээр салбарын яамнуудтай харьцуулахад болбол аймгууд бол нэлээд ийм өндөр түвшинд бас хэрэгжилттэй орж ирж байгаа. 80-аас дээш хувийн хэрэгжилттэй Ховд, Дундговь, Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Булган, Төв, Хөвсгөл гэсэн аймгууд бол Төв гэсэн эхний 7 аймаг болбол 70-аас дээш хувийн хэрэгжилттэй. Тэгээд цаашаа доошоогоо аймгууд бол энэ шалгуур үзүүлэлтээр болбол дүгнэгдсэн байдаг. Зарим нэг үнэлгээг болбол төсөв байхгүйгээс гадна бас ОУБ-ын санхүүжилтээр дээр бол тухайн аймаг, нийслэл, дүүргүүдийг бас сонгож энэ үнэлгээг бол хийдэг байгаа гэдгийг танд хэлье. Санхүүжилт бол нийт 21, 22 оны хугацаанд болбол 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд болбол 2 тэрбум 300 орчим сая төгрөгийг жендерийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бол төлөвлөж зарцуулсан байна.

П.Анужин: Сувилагчийн асуудалтай холбоотой асуултад эхлээд ЭМЯ, 2 дахид нь Зулпхар сайд хариулчихъя. Ер нь энэ хүний нөөцийн бодлого дээр тийм ээ бид нар сувилагчаа гаргаад байна гээд л мэдээд байгаа. Яг энэ хүний нөөцийн бодлого дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ямар бодлого баримталж байгаа юм бэ? Тусгайлсан бодлого байна уу гэдэг дээр гүйцээгээд хариулт авъя. 7 номерын микрофон Төгсдэлгэр дарга хариулт өгье.

С.Төгсдэлгэр: Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн асуудал бол үнэхээр хүндрэлтэй байгаа. Олон улсад бол эмч, сувилагчийн харьцаа 1, 4 байх ёстой. 1, 4 байдаг. Манай улсын хувьд болбол 1-ийг харьцах нь 2-т хүргэхийг зорьж байгаа. Гэтэл өнөөдрийн яг бодит

байдлаар болбол нэгийг харьцах нь нэг, түүнээс доошоо орчхоод байгаа. Тэгэхээр сувилагчийн хомсдолын асуудал бол үнэхээр тулгамдсан асуудал яах аргагүй мөн байгаа. Тэгээд 23 онд бид нар энэ эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааныхаа суурь судалгааг хийсэн. Энэ суурь судалгаагаар болбол манай нийт эмч, эмнэлгийн ажилчдын өрхийн анхдагч хэрэгцээний хүрэлцээнийх нь оноо нь нийт 5 баллаар үнэлэх юм бол 2,7 буюу өл залгаж амьдрах ийм түвшинд байна гэдгийг бол энэ судалгаа харуулсан. Тэгэхээр яалт ч үгүй бид нар энэ цалингийн асуудлыг нэмэгдүүлэх асуудал дээр бол онцгой анхаарч ажиллаж байгааг Бейсен гишүүн бас мэдэж байгаа байх.

Энэ ЗГ-ын зүгээс нэлээн бас тодорхой хэмжээний цалин нэмэгдүүлэх асуудлуудыг шийдвэрлэсэн байгаа. Мөн одоо болбол ингээд сумын эмч, аймгийн эмч, сувилагч нарын орон нутгийн нэмэгдлийг бол ялгавартайгаар олгож байгаа. Энэ дээр болбол өөрчлөлт оруулаад ирэх оноос болбол энэ ялгавартай байдлыг нь арилгах, эмч эмнэлгийн ажилчдын цалинг 10 хувиар, бусад нийтлэг үйлчилгээний ажилтны цалинг үүнээс 2 дахин их бүр 20 хувиар нэмэгдүүлэхээр ингээд бид нар төсөвт тусгасан байгаа. Тэгэхээр энэ дээр бас тодорхой хэмжээний ахиц гарах байх гэж найдаж байна. Ингээд орон нутгийн нэмэгдлийг болбол эмч, сувилагчид ялгаатайгаар тогтоохгүйгээр сум, сумд 40 хувиар, аймгийн төвд 20 хувь байхаар ингээд бас нэлээн 2 дахин нэмэгдүүлж байгаа. Энэ нь бас тодорхой хэмжээгээр хөшүүрэг болох байх гэж найдаж байгаа. Гэхдээ жишээлбэл Солонгос улсад хар ажил хийгээд авч байгаа цалинтай харьцуулахад энэ нэмэгдэл болбол бодит хөшүүрэг болох боломж бол хязгаарлагдмал гэдгийг хаана хаана хүлээн зөвшөөрч байгаа. Энэ дээр болбол яалт ч үгүй нэлээн томоохон өөрчлөлт орж байж л манай салбарт хүний нөөцийг татах асуудал.

Нөгөө нэг юм нь болбол үйлчлүүлэгчдийн зүгээс, энэ олон нийтийн хэвлэл мэдээллийн зүгээс ч гэсэн энэ эмч, эмнэлгийн ажилчид руу дайрах дайралт нэлээн ихдэж байгаа нь энэ хүний нөөц манай салбараас дайжих нэг том шалтгаан болж байна. Хамгийн сүүлд хийсэн судалгаагаар нийт ажилчдын 75 хувь нь үйлчлүүлэгчдийнхээ зүгээс ямар нэгэн байдлаар хэл амаар доромжлох, дайралтад өртөх гэх мэтийн ийм хүчирхийлэлд өөрсдөө өртөж байгаа учраас энэ салбараас дайжих ийм явдал бол яалт ч үгүй гарч байна. Тэгэхээр энэ дээр бас үйлчлүүлэгчдийн зүгээс ч гэсэн энэ нөгөө нэг энэ хэвлэл мэдээллээр ч гэсэн энэ салбар луу дайрч байгаа энэ дайралтуудыг бас нэлээн бууруулахгүй болбол манай салбар үнэхээр хүний нөөцийн хувьд болбол нэлээн том асуудалд орж байгаа.

П.Анужин: Гүйцээгээд энэ сувилагчийн талаар хүний нөөцийн бодлого дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Энэ зараар бол сувилагч авна гэсэн зар битүү. Гэтэл нөгөө талд иргэнийг буруутгах арга байхгүй. Сая ЭМЯ хариулж байна. Сувилагч нар маань өл залгуулах хэмжээнд залгах хэмжээнд цалин авч байгаа учраас. Тэр явж байгаа иргэнийг буруутгах аргагүй. Тэгэхээр энэ нөхцөл байдлуудыг хэрхэн шийдэх вэ гэдэг тал дээр Булгантуяа сайд хариулт өгье.

Х.Булгантуяа: Хүний нөөцийн асуудал бол ер нь манай ганц эрүүл мэнд гэлтгүй бараг салбар болгон дээр хүний нөөцийн дутагдал бий болсон. Ялангуяа манай үйлчилгээний салбарууд, манай төрийн мэргэжлийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, аймаг, орон нутгуудад сая 20-оос 40 хувийн ер нь төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийг нэмж олгохоор шийдвэрлэсэн нь аймаг, орон нутагт бол ялангуяа нарийн мэргэжлийн хүмүүс, багш нар, төрийн захиргааны албан хаагчид ч

гэсэндээ ажилладаггүй, удаан хугацаанд ажилладаггүй, олддоггүй. Тавьж байгаа шалгуурууд нь бол аймаг, орон нутагт ажиллалаа гээд хөнгөн шалгуур бол ерөөсөө тавьдаггүй. Тэгэхээр ийм үүднээсээ бид нар сая энэ төрийн албан хаагчдын цалинг бол нэмэгдүүлж байгаа. Төрийн албан хаагчдыг ер нь эрүүл мэндийн салбар гэлтгүй тогтвор суурьшилтай ажиллуулахад бид нар хэд хэдэн зүйлийг хийх ёстой.

I дүгээрт боловсон хүчнийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, бэлдэх ёстой. Түрүүн бас малчдын асуудлыг ярьж байна. Ер нь яах вэ Монгол Улсын нийт хөдөлмөрийн зах зээл, дээрээс нь нийгмийн хамгааллын асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцдаг ч гэсэндээ салбар болгон өөрөө өөрийнхөө салбарын боловсон хүчнийг салбарынхаа хөгжлийн зорилгын хүрээнд заавал авч үздэг. Жишээлбэл хөдөлмөр, эрүүл мэндийн салбарын зорилтын 2.2.8 дээр эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна гэж орсон байдаг. Сая Боловсролын багц хуулийг батлахад нийгэм, боловсролын салбар, бас боловсролын салбарынхаа боловсон хүчнийг бэлтгэх талаар бодлогынхоо баримт бичгийг хууль дээрээ ч гэсэндээ маш тодорхой тусгасан байдаг.

Тэгэхээр салбар болгоны нарийн боловсон хүчний асуудлуудыг салбар нь өөрөө бодлогоороо тодорхойлдог, тэрүүнийг Боловсролын яамтайгаа хамтран бэлтгэдэг. Манай яамтай нийгмийн хамгаалал, баталгааг нь хангах дээр хамтран ажилладаг ийм ер нь зохицуулалттай байдаг. Тэрнээс биш салбар болгоны жишээлбэл эрүүл мэндийн салбарын маш нарийн мэргэжлийн эмч нарын асуудлыг, энэ стандартын дагуу нарийн боловсон хүчний асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам салбар болгоны нарийн асуудлуудыг нарийвчлан шийдэхэд, мэдэхэд ч гэсэндээ бас их хүндрэлтэй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас

бид нар 10 гаруй жилийн дараагаар хөдөлмөрийн зах зээлийн томоохон судалгааг хийж байна.

Ер нь ингээд харахад манайд Боловсролын зээлийн сангаас, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар, МҮСТ дээр тэтгэлгээр гээд ингээд маш олон төрлийн дэмжлэгийг Монгол Улсын боловсон хүчнийг бэлтгэх чиглэлээр хэдийгээр олгогдоод байсан ч гэсэндээ харамсалтай нь ингээд харахад хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт 2 хоорондоо уулзалдаагүй харагдаж байна. Ийм олон их дээд сургуулиуд, 100 гаруй их дээд сургуулиудаар хүмүүс бэлтгэгдээд байгаа мөртөө нөгөө талдаа ажил олгогчид ажилтан олдохгүй байна. Ажилтан олоо гэхэд нөгөөдөх нь шаардлагыг нь хангахгүй, ахиад зайлшгүй бэлтгэгдэх ийм хэрэгцээ шаардлага үүсдэг.

Эсхүл бид нар гадагшаа зөндөө олон оюутнуудыг явуулаад байгаа мөртөө нэн шаардлагатай боловсон хүчнээ өөрснөө захиалж мэддэггүй. Гадаад руу бараг жилд 2 мянга орчим хувиар оргил үедээ бид нар олгож байсан. Тэгсэн мөртөө 2 мянган хуваарь дээрээ эрүүл мэндийн салбараа, боловсролын салбараа бэлдчихгүй яасан юм. Одоо ингээд хэдэн жилийн дараагаар бүгдээрээ аль, аль салбар нь боловсон хүчингүй болчихсон гээд эсрэгээрээ бэлтгэгдсэн хүмүүс нь болохоороо яг төрд ч битгий хэл, хувьд битгий хэл төрд ч өнөөдөр нэн шаардлагатай хүмүүсээ бэлдэж чадаагүй ийм л харагдаж байна. Тэгээд боловсон хүчний асуудал ярих юм бол манай салбарт ч хүнд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан тусгай хэрэгцээт боловсрол, сэргээн засах эмч нар, хүүхэд хамгааллын нарийн мэргэжилтнүүд, хөдөлмөрийн эдийн засагч гэх мэтчилэн ийм нарийн мэргэжлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нарийн мэргэжлийн хүмүүс гээд энэ бүх хүмүүсийг бид нар

нарийн мэргэжил мэргэжлээр нь бэлтгэж авах хэрэгцээ шаардлага байгаа.

Тийм учраас хөдөлмөрийн зах зээлийн томоохон судалгааг хийгээд, тэрүүгээр нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам салбарын яамнууд нь Боловсролын яамандаа захиалга өгдөг, Боловсролын зээлийн сангаараа энэ хүмүүсийг нь бэлтгэдэг, ингээд бэлтгэгдээд ирсэн хүн маань энд хөдөлмөрийн зах зээл дээр ажлын байр нь бэлэн байж байдаг, эрэлт хэрэгцээ нь байж байдаг ийм л байдлаар бид нар бэлдэхгүй бол бэлдчихээд бид нарын бэлдсэн хүмүүсийг зах зээл авах байлгүй дээ гэдэг ийм хандлага бол явахааргүй байгаад байгаа. Тийм ч учраас Монголд ажилгүйдлийн түвшин өнөөгийн нөхцөл байдалд.../минут дуусав/

П.Анужин: Бейсен гишүүн тодруулъя 1 минут.

Б.Бейсен: Би энэ салбарынхныгаа хамгаалах гэж байгаа юм биш л дээ. Саяын сувилагч нарын асуудал дээр ер нь эмнэлгийн удирдлагууд ажиллахгүй байна. Чанарын алба байж байна, эмчилгээний алба байж байна, сувилахуйн алба байж байна, эмийн алба байж байна, хяналт шинжилгээний алба байж байна. Эд нар гадаадын өндөр хөгжилтэй орнууд дээр 5 дахь өдөр яг ажил дуусахаас нэг цагаас хойш бүх эмнэлгүүдээ шалгаад, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эмээр хангадаг. Гэтэл энүүгээр хангахгүй байна шүү дээ. Энийг хэзээ нэвтрүүлэх вэ ЭМЯ? Эмнэлгүүд дээр хэзээ нэвтрүүлэх вэ, энийгээ нэг хэрэгжүүлэхгүй бол бас сувилагч нарын хэлмэгдэл, ажлаас гарах, халирах хүнд нөхцөлтэй байна шүү дээ. Сувилагч, асрагч нарын ажил маш хүнд байна. Би мэдэж байна, эмнэлэгт ажиллаж байгаад. Энийг нэвтрүүлэх шаардлагатай байна ерөөсөө. Ажлын нөхцөлөөр хангах асуудал дээр анхаарахгүй бол болохгүй нь гэдгийг хэлье.

П.Анужин: Бейсен гишүүн санал хэллээ. Асуусан бусад асуулт өнөөдрийн хэлэлцэгдэж байгаа асуудалтай шууд хамааралгүй учраас Бейсен гишүүнд түрүүний бас үүрэг болгож өгсөн бичгээр хариултаудыг нь бас тодорхой тусгаад өгөхийг хүсье яамнуудаас. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Сандаг-Очир: ЗГ-аас жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хуулийн хүрээнд, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайлангаа оруулж ирж байгаа юм байна. Яах вэ дээ бодит байдал дээрээ яамнуудаасаа, агентлагуудаасаа, 21 аймаг, 9 дүүргийнхээ Тамгын газраас л тэгээд л үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт гээд л ингээд нэг нэгтгэж аваад л, оруулж ирж байгаа л даа. Тэгээд жендерийн байдлыг хангана гэхээр яг үнэнийг хэлэхэд нэг эмэгтэй улс төрчдийг Улсын Их Хуралд нэр дэвшүүлэх, эмэгтэй сайд нарыг нэг ЗГ-т багтаах гэсэн ийм ерөнхий ойлголтоор л ханддаг юм шиг надад ойлгогдоод байгаа юм. Энэнээс хэтрэхгүй байна л гэж хэлэх гээд байна. Тэгэхээр юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр жендерийн эрх тэгш байдлыг хангах энэ хөтөлбөрийн ажил чинь энэ Саарал ордноос хэтрэхгүй байна. Орон нутагт энэ хөтөлбөр үнэхээр хэрэгжихгүй байна л гэж би хэлэх гэж байгаа юм.

Энэ жендерийн талаарх орон нутгийн удирдлагууд, байгууллага ААН-үүдийн удирдлагууд мөн төрийн өмчийн оролцоотой төрийн өмчийн компаниуд 100-аас дээш ажилтнуудтай томоохон байгууллагууд дээр энэ чиглэлийн ойлголт хандлага ерөөсөө огт байхгүй. Тэгэхээр ерөөсөө иргэдээс та бүхэн асуугаарай, жендер гэж ойлгохоор юу гэж ойлгодог юм. Тэгээд ерөөсөө нэг Их Хуралд нэг олон эмэгтэйчүүдийг оруулчихвал л жендерийн бодлого хэрэгжиж байгаа гэж ойлгогдох гээд байна уу, яах гээд байна вэ? ЗГ-т хэдэн эмэгтэй сайд нарыг

оруулчихвал жендерийн бодлогыг сайн хэрэгжүүлж байгаа гэж ойлгогдох гээд байна уу? Бүх шатын сонгуульд нэг эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлчихвэл энэ бодлого зорилт хангагдчих гээд байгаа юм шиг ийм ойлголтоор төсөөлж ингээж ханддаг болчихсон шүү.

Тийм учраас энэ орон нутаг энэ Саарал ордноосоо хальж, энэ орон нутагт энэ жендерийн бодлого чинь хэрэгжихгүй байгаа шүү л гэдгийг хэлье. Орон нутагт энэ салбар хороо, зөвлөлүүд чинь үндсэндээ энэ чиглэлээр нэг сэтгэлтэй хэдэн төрийн бус байгууллагууд, тэгээд гадаад, дотоодын санхүүгийн байгууллагуудаас нэг ганц нэг төсөл авдаг, төслөө хэрэгжүүлж явдаг, нэг ганц нэг орон нутгийн төлөөлөгч нарт нэг сургалт хийх төдийхнөөр л ийм байдлаар л орон нутагт жендерийн асуудал чинь явж байгаа. Яг үнэнийг хэлэхэд. Тэрнээс өөр байдлаар орон нутгийн удирдлагуудыг орон нутгийн дэд хөтөлбөрүүд дээр баахан хөтөлбөр, дэд хөтөлбөрүүд, зорилт төлөвлөгөө хэрэгжүүлнэ гээд баталчихсан байдаг. Амьдрал дээрээ хэрэгждэггүй. Яг төсөв төлөвлөгөө хэлэлцээд эхлэхээр нөгөө эдийн засгаар баталгаажсан энэ нөгөө ажлууд нь байхгүй болдог. Бодлого орон нутагт хэрэгждэггүй. Тэгээд төсөв байхгүй болохоор энэ үйл ажиллагаа чинь цаашидаа явуулахад хүндрэлтэй болдог. Нөхцөл байдал яг л ийм байгаа юм. Тэгээд сайхан цаасан дээр буусан төлөвлөгөө хөтөлбөрүүд бол хангалттай байгаа. Гагцхүү цаанаа хэрэгжих эдийн засгийн баталгаа юм байхгүй, ингэж л орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилт бас ийм байдалтай яваа л гэж би бол хувьдаа ингэж хардаг. Та бүхэн маань юу гэж харж байгаа юм бэ? Энэ хөтөлбөрүүд яг орон нутагт хэрхэн яаж дэд хөтөлбөрүүд нь хэрэгжиж байгаа юм бэ? Одоо энэ чиглэлээр явуулж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа хэр идэвхэжсэн юм, хэр тогтвортой байж чадаж байгаа юм, хэчнээн энэ чиглэлээр жендерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа

төрийн бус байгууллагууд байгаа юм бэ? Тэдгээр нь орон нутгийнхаа төр захиргааны байгууллагатай хэр уялдаатай ажиллаж байгаа юм, орон нутгийнхаа төр захиргааны байгууллагуудын гаргаж байгаа бодлого, шийдвэрт хэзээ, яаж хамгийн сүүлд дүгнэлт, хяналт шинжилгээ хийсэн юм, орон нутгийн тэр бодлого шийдвэрийнх нь хэрэгжилт ямар хувьтай байгаа юм гэдгийг ер нь яаж авч хэлэлцэж үзэж байгаа юм бэ? Жендерийн Үндэсний хороо. Энэ дээр та бүхэн бас нэг хариулт өгөөч гэж хэлье. Баярлалаа.

П.Анужин: 5 номерын микрофонд Жендерийн үндэсний хороо Энхбаяр дарга хариулт өгье.

Т.Энхбаяр: Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дээр 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргаас Тамгын газраас тайлан боловсруулаад энэхүү тайланг ИТХ-аараа хэлэлцүүлээд, Жендерийн хороонд хүргүүлэх гэдэг ийм хуулийн заалттай. Энэ заалтын хүрээнд болбол 2018 он хүртэл бас Жендерийн үндэсний хорооны Ажлын алба салбарын яамны бүтцэд байсантай холбогдуулаад энэ тайлан бас янз бүрийн байдлаар бол авдаг, ирдэг, нэгтгэгддэг байсан. Бид нар 19 оноос хойш тогтвортойгоор сүүлийн 4 жил энэ тайланг авахдаа ҮСХ-ноос батлуулсан маягтын дагуу олон нийтэд нээлттэй байршуулах байдлаар ингэж тайланг бол авч ажиллаж байна.

Сүүлийн 4 жилийн хугацаанд Сандаг-Очир гишүүний хэлснээр 4 асуудлыг та тодруулж байх шиг байна. 1 дүгээрт нь жил болгон бид нар тайланг бол авч байгаа. Энэ тайланг бол үнэлээд, дүгнээд, зөвлөмжийн хамтаар хүргүүлж байгаа. 21, 22 оны тайлант хугацаанд хамарч байгаа учраас ерөнхийдөө 2,3 тэрбумыг дэд хөтөлбөр хэрэгжүүлэхэд болбол орон нутгууд бол хамтарч ажиллажээ. Энэ тайланг хэрэгжүүлж ажиллаж байна. Энэ мөн тайлан хэрэгжилтийн байдлаар аймгууд 31 шалгуур үзүүлэлтүүдээр бид нар бас

үнэлж ингэж гаргасан байгаа. Салбарын яамдтай харьцуулахад бол орон нутгийн жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт бол харьцангуй бас 20-иод хувиар илүү байгаа гэдгийг энэ тайлангаар бол гарсан байгаа.

Дараагийн асуудал нь бол иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах чиглэлд сүүлийн 2 жил бол бид нар 1 аймгийн 5 ТББ-ыг ЗДТГ-тай нь хамтраад, хамтарч ажилладаг болон өөрсдийнх нь МҮХАҮТ, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоодын ТББ-ын төлөөллүүд байгаа. 5 ТББ-ыг сонгоод, нийт 21 аймгийн 105 иргэний нийгэм, ТББ-ыг жендер мониторинг хийх чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулсан. Тэгээд ер нь 10 ТББ-д 2000 хүртэлх доллар, 2000 долларын тэтгэлэг өгөөд, өөрсдөө яг нөгөө хөтөлбөрөө үнэлэнгээ суралцъя гэдэг энэ бас үйл ажиллагааг ингэж зохион байгуулсан байгаа. Тэгэхээр Жендерийн хорооны бүрэлдэхүүний 50 хувь нь өөрөө төрийн бус байгууллагууд байдаг. Тэгэхээр илүү бид нар нөгөө иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай илүүтэй хамтарч, яг төрийн жендерийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа бодлого дээр ТББ өөрөө хамтарч ажиллах энэ зохион байгуулалт дэмжлэгийг нь бас хийж байна гэдгийг танд хэлье.

Мөн 21 аймаг, нийслэл, 9 дүүрэг дээр төрийн албан хаагчдын жендерийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлд сүүлийн 2,5 жил бас Удирдлагын академи энэ дээр болбол маш хүчин чармайлт гаргаж бас ажиллаж байгаа гэдгийг танд бас цохон тэмдэглэе. Орон нутагт байгаа хувийн хэвшлийн байгууллагуудад болбол тодорхой нэгдсэн холбоодоор нь дамжуулаад энэ хөтөлбөрийг хүргэх ажлыг бол хийж байгаа. Дээр нь ИТХ-тай бас хамтарч ажиллах хамгийн том зорилт бол байгаа. Тэгэхээр ИТХ зөвхөн тайлангийн нүүр зүүгээд явуулахаасаа илүүтэй хурлын төлөөлөгчдийн жендерийн

талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтын модуль бол боловсруулагдаад, сургагч багшийг нь бэлтгэж өгөөд, орон нутаг дахь ХЭҮК-ын ажилтантай хамтраад энэ асуудлуудыг сум бүрд хүргэх энэ ажил нь болбол бас хийгдэж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

П.Анужин: Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хэрэгжилтийн талаарх ЗГ-ын тайланг бид сонсож, Нийгмийн бодлогын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо хамтран сонсож, гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Төгсгөлд нь би бас 2 зүйлийг хэлье гэж бодож байна. Өнөөдөр бид нар энэ Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн талаар бас гишүүд маань олон талаас нь ярьж, асуулаа. Гэхдээ бид нар нэг зүйлийг огт дурдсангүй. Үүн дээр би үүрэг өгөхийг хүсэж байна. 2017 оны 11 дүгээр сарын, 5 дугаар сарын 11-нд Эрүүгийн хуулиас ажлын байран дээрх бэлгийн дарамт болбол үзүүлсэн энэ нөхцөлд эрүүгийн ял хүлээлгэдэг энэ зүйл заалтыг бол хассан байгаа, хассан байдаг. Хассанаараа энэ асуудал ер нь энэ байгууллагууд дээр хэрхэн шийдэгдсэн юм бэ? Бид нар энэ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс үзэхэд бол хэцүү юм яригдаж байгаа. Тэгэхээр энэ байдал яг бодит байдал дээр ямар байна вэ гэдгийг бүх яамнууд үнэлгээгээ хийж, үнэлгээ судалгаа хийсэн байгаа бол энэ хуулийг бид нар эрүүгийн ял авахгүй ингэж болгосноороо өнөөдөр байдал яаж эергээр шийдэгдсэн юм уу, нэг бол ерөөсөө манай Монголын нийгэмд энэ асуудал байхгүй байна. Энийг болбол Эрүүгийн хуулиар яллах онцгой шаардлага байхгүй гэж үзсэн нь зөв байсан юм уу гэдэг тал дээр бид нар ямар ч үнэлгээ дүгнэлт ярьсангүй. Энэ асуудал дээр ойрын хугацаанд яамнууд тодорхой хариулт өгөхийг Нийгмийн бодлогын байнгын хороо бас үүрэг болгож байна.

2 дугаарт нь Монголын нийгмийн асуудал болсон. Гол шалтгаан нь бол

эрүүл мэнд, архидалт, нийгмийн ядуурал гэсэн энэ үзүүлэлтүүдээс болж эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалт 9,6 хувиар зөрлөө гэдгийг амаа хаттал бүх хүн ярьж байна, цээжилчихсэн байна. Гэхдээ өнөөдөр бид нар огтхон ч тодорхой хариулт өгсөнгүй. Арга хэмжээ авах шаардлагатай, амьдралын нөхцөлийг дээшлүүлэх шаардлагатай, архиа багасгах шаардлагатай. Тийм шаардлагатай. Энийг жирийн иргэн хэлнэ. Тэгвэл ямар арга хэмжээ авах бодлого боловсруулсан юм бэ гэдгээ бас холбоо, харьяа яамнууд ойрын хугацаанд Нийгмийн бодлогын байнгын хороонд бичгээр ирүүлнэ үү гэдэг энэ 2 үүргийг өгч байна. Сонсголын төгсгөлд.

2 Байнгын хорооны хамтарсан хуралдаан хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөж байна. Хуралд идэвхтэй оролцсон тус 2 Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсгийн нийт гишүүддээ баярлалаа.

12.29 цаг

Хамтарсан хуралдаан өндөрлөснийг мэдэгдэж байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

